



Премиум Нэксус ХК-ийн үйл ажиллагааны тайлан

2024





Ирээдүйг чиглэсэн мэдэгдлийн анхааруулга

- ◆ Премиум Нэксус ХК-ийн энэхүү тайланд ирээдүйг чиглэсэн мэдэгдлүүд багтсан болно. Эдгээр мэдэгдлийг танихын тулд "Бид таамаглаж байна", "Бид тооцоолж байна", "Бид зорьж байна", "Бид төлөвлөж байна" гэх мэт үг хэллэг эсвэл ирээдүй цаг дээр бичигдсэн байдлыг анхаарна уу.
- ◆ Ирээдүйг чиглэсэн мэдэгдэл нь ирээдүйд болох үйл явдлын баталгаа биш бөгөөд бидний төсөөлж буй зүйлс биелэхгүй байж болзошгүй. Иймд эдгээр таамаглалд хэт их найдлага тавих нь үндэслэлгүй юм.
- ◆ Компанийн бизнесийн үйл ажиллагааны чиг хандлага нь тайлангийн "Гүйцэтгэх удирдлагын тайлан" хэсэгт дурдсан эрсдэл, тодорхойгүй байдал болон бусад хүчин зүйлээс шалтгаалан өөрчлөгдөж болно. Эдгээр эрсдэл, тодорхойгүй байдлыг харгалзан үзэж, ирээдүйг чиглэсэн мэдэгдэл, төсөөллийг шууд утгаар нь биелнэ гэж ойлгох нь эрсдэлтэй.
- ◆ Мөн бид шинэ мэдээлэл, ирээдүйд гарах үр дүн эсвэл бусад шаардлагын улмаас тайланд тусгагдсан ирээдүйг чиглэсэн таамаглалуудыг заавал шинэчлэх эсвэл өөрчлөх үүрэг хүлээхгүй болно



Учирч болзошгүй эрсдэлүүд

1. Нийлүүлэлтийн сүлжээ тасалдах эрсдэл

445 CU конвиниенс сүлжээ дэлгүүрүүдээр дамжуулан **+59 сая** худалдан авалтыг найдвартай, байнгын бараа бүтээгдэхүүнээр хангаж, хэрэглэгчдэд хэзээд хүссэн барааг нь бэлэн байлгах асар том дэд бүтцийн хувьд хамгийн том эрсдэл бол нийлүүлэлтийн шугам доголдох эрсдэл юм. Бизнесийн цар хүрээ нэмэгдэхийн хэрээр уг эрсдэлийн нөлөөлөл томорч, алдагдсан боломжийн зардал өсөж байна. Иймд Премиум Нэксус ХК нь ханган нийлүүлэлтийн найдвартай байдлыг хангах үүднээс нийт бараа бүтээгдэхүүний 99.99%-ыг өөрийн түгээлтийн төвөөр дамжуулан нэгдсэн бүтээгдэхүүн удирдлагаар уг эрсдэлийг бууруулан ажиллаж байна.

2. Брендийн нэр хүндийн эрсдэл

Олон улсын франчайз эрх эзэмшиж буйн хувьд үйлчилгээний стандарт алдагдаж брэндийн нэр хүнд унах, харилцагчдын итгэлийг алдах нэр хүндийн эрсдэл үүсэх магадлалтай. Нэр хүндийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор Компани нь хэрэглэгчтэй шууд харилцдаг дэлгүүрийн ажилтнуудад QSC үйлчилгээний стандартын сургалтыг тогтмол явуулж, хэрэглэгчийн гомдол, саналыг нээлттэй хүлээн авах, барагдуулах харилцагчийн үйлчилгээний төвийг ажиллуулах замаар эрсдэлийг бууруулан ажилладаг.

3. Өрсөлдөөний эрсдэл

Жижиглэн худалдааны зах зээлд өрсөлдөөн нэмэгдэж ойролцоо байршил дах хүнсний дэлгүүр, конвиниенс дэлгүүрийн тоо нэмэгдсэнээр нэгж дэлгүүрийн болон дундаж борлуулалт буурах, хэрэглэгчдийн тоо хуваагдах эрсдэлтэй. Компани нь зах зээлд давамгайлах стратегийг хэрэгжүүлж, хүн амын хөдөлгөөний урсгал байршлуудад түргэн байршиж, өөр хоорондоо оновчтой зайтайгаар буюу 150-200 метрийн зайд конвиниенс дэлгүүрийг тэлснээр өрсөлдөөнд давуу байдлыг бий болгож, тус эрсдэлийг бууруулж ажилладаг..

4. Хууль зүйн орчин, журмын тогтворгүй байдлын эрсдэл

Жижиглэн худалдааны бизнес, тэр дундаа ая тухтай дэлгүүрийн бизнесийн үйл ажиллагаанд шууд нөлөөлөх хууль эрх зүйн орчны зохицуулалтын уялдаа холбоогүй, тогтворгүй байдал компанийн дунд болон урт хугацааны шийдвэрт ойлгомжгүй байдал үүсгэх эрсдэлтэй. Иймд бид холбогдох хууль тогтоомж, стандарт, захирамж болон бизнесийн хэв шинжийг уялдуулан бизнес төлөвлөгөө, стратеги боловсруулан төлөвлөх замаар уг эрсдэлийг бууруулан ажилласан.

5. Чадварлаг хүний нөөцийн хомсдол үүсэх эрсдэл

Жижиглэн худалдааны салбарт өрсөлдөгч нэмэгдсэн нь чадварлаг ажиллах хүчний хомсдол үүсэх эрсдэл бий болгож байна. Компанийн брэндингийг сайжруулах, бидний үнэт зүйлст нийцэх хүмүүсээр ажил горилогчийн сангаа бүрдүүлж, уг санг үргэлж нэмэгдүүлж, бизнесийн шаардлага хэрэгцээнд нийцсэн ажиллах хүч бэлтгэх хөтөлбөр боловсруулан уг эрсдэлийг бууруулж байна.



Агуулга

КОМПАНИЙН ТУХАЙ

ТУЗ даргын мэндчилгээ	6
Гүйцэтгэх захирлын мэндчилгээ	7
Түүхэн замнал	8
Премиум Нэксус	10
Онцлох үйл явдлууд	14

БИЗНЕС

CU конвинеиенс дэлгүүрийн бизнес

Бидний бизнесийн хандлага, ёс зүй	1
Үйл ажиллагааны онцлог, давуу тал	1
Стратегийн зорилтууд	1
Үйл ажиллагааны гүйцэтгэл	1

Бусад охин компаниуд

Сэнтрал Фүүдс ХХК	1
Сэнтрал Кофе Рөүстинг ХХК	1
Сэнтрал Коммерс ХХК	1
Чингис Шар Айраг ХХК	1
Премиум Нэксус Ложистикс ХХК	
Стора Централ ХХК	

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Байгаль орчин	1
Нийгэм	1
Компанийн засаглал кодексын өөрчлөлт	1

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Санхүүгийн гүйцэтгэл	1
Нэгтгэсэн орлого, үр дүнгийн товч тайлан	1
Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан	1
Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	1

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Дэлгэрэнгүй орлогын тайлан	1
Санхүүгийн байдлын тайлан	1
Мөнгөн гүйлгээний тайлан	1
Өмчийн өөрчлөлтийн тайлан	1



КОМПАНИЙН ТУХАЙ

ТУЗ даргын мэндчилгээ	6
Гүйцэтгэх захирлын мэндчилгээ	7
Түүхэн замнал	8
Премиум Нэксус	10
Онцлох үйл явдлууд	14



ТУЗ-ийн даргын мэндчилгээ

Эрхэм хүндэт хөрөнгө оруулагчид аа,

2024 он Премиум Нэксус ХК-ийн хувьд ашигт ажиллагаанд хүрсэн онцлох жил болж өнгөрлөө. Бид үйл ажиллагаагаа Улаанбаатар хотоос орон нутаг руу тэлэн Монголын орон даяар өргөжүүлэх замыг тавилаа. Энэ үе шат бидний хувьд бизнесийн өсөлт, үр ашгаа нэмэгдүүлж, хувьцаа эзэмшигчдэд шинэ үнэ цэнэ бий болгох тууштай хүчин чармайлтын илэрхийлэл юм. Нийслэлд үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой гол сорилтуудыг давж, улсын хэмжээнд бизнесийнхээ хүртээмж, нөлөөллийг нэмэгдүүлэх стратегийн байр сууриа амжилттай бэхжүүлж байна.

Бидний амжилт цар хүрээ, тогтвортой хөгжлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлоготой салшгүй холбоотой. Бид нийлүүлэлтийн сүлжээгээ оновчтой болгож, бизнесийн загвараа улам бэхжүүлэн, засаглалын тогтолцоогоо сайжруулснаар урт хугацааны тогтвортой хөгжлийг бий болгохоор ажиллаж байна. Мөн хараат бус гишүүнээр ТУЗ-ийн даргыг томилсон нь манай компанийн ил тод байдал, хувьцаа эзэмшигчдийн үнэ цэнийг эрхэмлэх бодлогын илрэл юм.

Монголын компанийн засаглалын салбарт жишиг болсон БОНЗ-ийн хорооны үүсгэн байгуулсан явдал нь бидний нийгмийн хариуцлагыг улам бататгаж, хариуцлагатай бизнесийн шийдвэрүүд гарган, хэрэгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулж байна. Ирээдүйд бид одоогийн амжилтаа бататган, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлж, шинэ боломжуудыг нээхийг зорьж байна. Бидний бий болгосон суурь нь Премиум Нэксус ХК-ийг улам өндөр түвшинд хүргэх бөгөөд энэ замаар бүх оролцогч талуудад үр өгөөжийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Итгэл хүлээлгэсэнд баярлалаа.

Бид хамтдаа Премиум Нэксус ХК-ийн илүү хүчирхэг, эерэг ирээдүйг бүтээж байна.

Хүндэтгэсэн,

Гэри Стивен Биондо

ТУЗ-ийн дарга
Премиум Нэксус ХК



Гүйцэтгэх захирлын мэндчилгээ

Эрхэм хөрөнгө оруулагчид, бизнесийн түншүүд, ажилтан, хэрэглэгчид ээ,

2024 он Премиум Нэксус ХК-ийн хувьд тогтвортой өсөлт, ашигт ажиллагаагаар дүүрэн, амжилт бүтээл арвин жил боллоо. Бид анх удаа ₮28 тэрбумын үйл ажиллагааны цэвэр ашигтай ажиллаж, Чингис Шар Айраг ХХК-ийн бизнесийн нэгтгэлээс ₮19.5 тэрбумын нэмэлт ашиг олсноор нийт цэвэр ашиг ₮47 тэрбумд хүрэв.

CU конвиниенс дэлгүүрийн сүлжээ 445 салбарт хүрч, жилийн дүнгээр ₮598 тэрбумын борлуулалт, 59 сая хэрэглэгчтэй болж, зах зээлд тэргүүлэх байр сууриа улам бататгалаа. Бид 81 шинэ салбар нээн, 10 дэлгүүрийг өндөр үр ашигтай байршилд шилжүүлэн, өдөр бүр 420 гаруй ханган нийлүүлэгчтэй хамтран 170,000 хэрэглэгчид 2000 орчим нэр төрлийн бүтээгдэхүүн хүргэж байна.

Орон нутаг дахь 13 аймагт 50 салбар дэлгүүр ажиллуулж, хүнсний хангамж, ариун цэврийн хүртээмжийг нэмэгдүүлж, ажлын байр бий болгосноор дотоодын аялал жуулчлалд чухал нөлөө үзүүллээ.

Бид бизнесийн дэд бүтцээ өргөтгөн, үйл ажиллагааны стандарт, хүний нөөцийн чадавхыг сайжруулснаар урт хугацааны өрсөлдөх чадвараа улам бүр бэхжүүлж байна. Охин компаниуд маань – Чингис Шар Айраг, CU Хоолны Үйлдвэр, Стора – бүгд өөрийн салбартаа тэргүүлэх байр суурийг эзэлж, хэрэглэгчдэд олон улсын түвшний үйлчилгээ, бүтээгдэхүүнийг санал болгож байна.

Премиум Нэксус ХК-ийн хамт олон бид “Дэлхийн стандартаар хүмүүсийн өдөр тутмын амьдралыг хялбаршуулах” эрхэм зорилгодоо үнэнч байж, хэрэглэгч, хувьцаа эзэмшигч, түншүүд болон ажиллагсад та бүхний итгэлийг өндөрт өргөхийн төлөө ажиллаж байна. CU бизнесийн платформын оролцогч бүх талуудад бодит үнэ цэнэ бий болгож, зах зээлийн манлайлагч байр сууриа бэхжүүлэхийн зэрэгцээ үндэсний хэмжээнд тэргүүлэх компани болохын төлөө тууштай хөгжин дэвших болно.

Хүндэтгэсэн,

А. Ганхуяг

Гүйцэтгэх захирал
Премиум Нэксус ХК



Түүхэн замнал



2015

- Монголын хамгийн анхны конвiniенс дэлгүүр Сэнтрал Экспресс сүлжээг 3 салбар дэлгүүртэйгээр нээв.

2017

- Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийг үүсгэн байгуулав.

2018

- CU брэндийн мастер франчайз эрх эзэмшигч БНСУ-ийн Би Жи Эф Ритайл компанитай гэрээ байгуулж CU брэндийн франчайз эрх хүлээн авав.
- Монголын анхны “Анхны ая тухтай” дэлгүүрийн MNS гэрчилгээг авав.

2019

- CU брэнд 1 жилийн дотор 50 салбар дэлгүүртэй болов.
- CU үнэнч хэрэглэгчийн хөтөлбөрийг эхлүүлж CU аппликэйшныг нэвтрүүлэв.

2020

- Энгийн температурын горимтой 4200мкв талбайтай түгээлтийн төв ашиглалтад оров.
- Монголын хамгийн анхны 100 салбар дэлгүүртэй сүлжээ болов.
- Олон улсын GMP, HACCP стандартыг хангасан Монголын хамгийн анхны нийтийн хоолны үйлдвэр ашиглалтад оров.



Түүхэн замнал



2021

- Хүйтэн хэлхээний түгээлтийн төвийг ашиглалтад оруулав.
- CU брэнд хувьцаагаа гаргав.

2022

- Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК нь Сиркл Чейн ХХК-ийн Circle K сүлжээ дэлгүүрийн 12 салбарыг худалдан авах хэлцэлд гарын үсэг зурж баталгаажуулж авсан.
- CU сүлжээ дэлгүүрийн нэг өдрийн борлуулалт 1 тэрбум төгрөгт хүрэв.
- Монголын хамгийн анхны 200 салбар дэлгүүртэй сүлжээ болов.
- БНСУ-ын нөү хау бүхий Мэдээллийн технологийн цогц систем хөгжүүлж, сүлжээний хэмжээнд нэвтрүүллээ.
- CU брэндийн орон нутаг дахь анхны салбар дэлгүүр нээгдэв.

2023

- Топ 100 аж ахуйн нэгжээр 2 дахь удаагаа шалгарч, 11-р байранд эрэмбэлэгдлээ.
- Монголын хамгийн анхны 300 салбар дэлгүүртэй сүлжээ болов.
- CU брэндийн франчайз хөтөлбөрийг албан ёсоор эхлүүлэв.
- Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд хоолны үйлдвэрт айлчлал зохион байгуулав.

2024

- Үйл ажиллагааны ашигт ажиллагаанд хүрэв
- Топ 100 аж ахуйн нэгжээр 3 дахь удаагаа шалгарч, 8-р байранд эрэмбэлэгдлээ.
- Монголын хамгийн анхны 400 салбар дэлгүүртэй сүлжээ болов.



Премиум Нэксус

Компанийн тухай

Премиум Корпорэйшн нь 2015 онд өөрийн 100%-ийн хөрөнгө оруулалтаар Монголын анхны конвинеенс дэлгүүр болох Сэнтрал Экспрессийг үүсгэн байгуулсан.

2017 онд Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийг байгуулж, 2018 оны 8-р сард БНСУ-ын жижиглэн худалдааны тэргүүлэгч Би Жи Эф Ритэйл ХК-тай хамтран CU брэндийн мастер франчайз эрхийг авч, компанийн нийт хувьцааны 10%-ийг эзэмшүүлэх хөрөнгө оруулалт татан Монголын зах зээлд CU брэндийг нэвтрүүлсэн. Би Жи Эф Ритэйл ХК нь БНСУ-д 18,000 гаруй CU салбар дэлгүүртэй.


Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь 2021 онд Монголын Хөрөнгийн Бирж дээр IPO амжилттай хийж хувьцаат компани болсон. 2023 оны эцэст хувьцаа эзэмшигчдийн хурлаар компанийн нэрийг Премиум Нэксус ХК болгон өөрчилж, хөгжлийн дараагийн шатанд гарсан. Энэхүү өөрчлөлтийн хүрээнд Чингис Шар Айраг ХХК, Сэнтрал Коммерс ХХК, Сэнтрал Кофе Рөүстинг ХХК, Стора Централ ХХК зэрэг компаниудыг шинээр хувьцаа гаргах замаар нэгтгэж, босоо интеграцийн хөрөнгө оруулалт хийсэн.



Хоолны үйлдвэр, нэгдсэн түгээлтийн систем, 445 салбартай конвинеенс сүлжээ дэлгүүрийн үйлчилгээ.



CU төвтэй, нэгдсэн нийлүүлэлтийн гинжин хэлхээтэй цогц эко-систем.





Премиум Нэксус

Премиум Нэксусийн эко-систем ба түүний давуу талууд



Борлуулалт болон ашигт ажиллагааны өсөлт

CU сүлжээ дэлгүүртэй хамтран ажилласнаар ханган нийлүүлэгчид борлуулалтын төлөвлөлтөө оновчтой болгож, эрэлтээ зөв таамаглан, үргүй зардлаа бууруулах боломжтой. Энэ нь ханган нийлүүлэгчдийн бизнесийн хамтын ашигт ажиллагааг нэмэгдүүлнэ.



Байгал орчин, Нийгэм, Засаглалын өндөр стандарт өргөн цар хүрээ:

CU сүлжээ дэлгүүрийн ханган нийлүүлэгчид, ялангуяа жижиг, дунд үйлдвэрлэгчид Премиум Нэксусийн олон улсын жишигт нийцсэн БОНЗ-ын (ESG) туршлагыг өөрийн үйл ажиллагаандаа нэвтрүүлэх боломжтой.



Логистик болон нэгдсэн түгээлтийн үр ашиг

Монгол Улсын өнөөгийн дэд бүтцийн нөхцөл байдлаас шалтгаалан бүтээгдэхүүний нийт өртгийн 30 орчим хувийг логистикийн зардал эзэлж байгаа нь дэлхийн дунджаас 2-3 дахин өндөр үзүүлэлт юм. Премиум Нэксус нь логистикийн дэд бүтцийг сайжруулснаар энэхүү үр ашиггүй байдлыг арилгах боломжтой.



Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж

CU сүлжээ дэлгүүр үйлдвэрлэгчидтэйгээ хамтран бүтээгдэхүүн хөгжүүлснээр хэрэглэгчдийн хэрэгцээнд бүрэн нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой. Энэ нь хэрэглэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлж, үнэнч хэрэглэгчдийн тоог өсгөх боломжтой.



Хөрөнгө оруулагчдын нэгдмэл ашиг сонирхол

CU сүлжээ дэлгүүрийг түшиглэн үйл ажиллагаа явуулдаг бизнесүүдийг нэгтгэснээр хамтын хүчээр илүү үнэ цэнийг бий болгох боломжтой. Тус хамтралын хүрээнд хөрөнгө оруулагчид шинээр үүсэх бүх боломжуудаас ашиг хүртэх болно.




Ажиллагсдын өсөж дэвших боломж, сэтгэл ханамж

Монголын томоохон хөрөнгө оруулалтын компани болох Премиум Нэксус ХК-д ажилласнаар ажилтнууд групп компанийн хүрээнд өсөж хөгжих, Премиум туршлагаас суралцах боломжууд нээлттэй болно.



Премиум Нэксус


Бизнесийн бүтэц





Премиум Нэксус

Удирдлагын бүтэц





Онцлох үйл явдлууд

Монгол Улсын ТОП 100 аж ахуйн нэгж

8-р байр

Премиум Нэксус ХК - Монгол улсын ТОП 100 аж ахуйн нэгжийн 8-р байранд шалгарлаа!

2023 онд Монгол улс нийт 21.5 их наяд төгрөгийн татварын орлого төвлөрүүлсний 29% буюу 6.29 их наяд төгрөгийг ТОП-100 аж ахуйн нэгж бүрдүүлжээ.

Премиум Нэксус ХК нь Монгол улсын ТОП 100-д 4 дэх удаагаа багтаж, дараах амжилтуудыг үзүүллээ:

Борлуулалтын орлогоороо	35-р байр
Төлсөн татварын дүнгээр	80-р байр
Даатгуулагчийн тоогоор	2-р байр
Ашгийн хэмжээгээр	97-р байр
Хөрөнгийн эрэмбээр	91-р байр
Нийт дүнгээр	8-р байр





Best Training

Сургалт, хөгжлийг дэмжигч шилдэг ажил олгогч

Премиум Нэксус ХК - "Mongolian Labor Market Summit: Good Workplace Awards 2024" арга хэмжээний Сургалт хөгжлийг дэмжигч шилдэг ажил олгогчоор шалгарлаа.

Хөдөлмөрийн зах зээлийн хамгийн том чуулган болох "MONGOLIAN LABOR MARKET SUMMIT: Good Workplace Awards 2024" нь хүний нөөцийн салбарын хүндэтгэлтэй байгууллагуудыг шалгаруулдаг нэр хүндтэй арга хэмжээ юм. Энэ удаагийн шалгаруулалтад 270 гаруй компанийн материалыг 10 номинацийн хүрээнд хүлээн авсан бөгөөд олон талт шүүгчдийн бүрэлдэхүүнтэй онооны системээр үнэлжээ.

Энэхүү амжилт нь компани ажилтнуудынхаа тогтвортой хөгжил, ур чадварын ахиц, олон улсын хөдөлмөрийн стандартыг мөрдөх зэрэг хувь нэмрийг өндрөөр үнэлснийг илтгэж байна.

2023-2024

22,919 ажилтанд

122,981 хүн цаг

2023-2024 онд сургалтын баг нийт **22,919** ажилтанд **122,981** хүн цагийн сургалтыг **830** удаагийн давтамжтай хүргэжээ.

2023-2024

1,293

387

Сургалтад суусан ажилтнуудаас **1,293** ажилтан карьер зэрэглэл хөндлөн чиглэлд ахисан бол босоо чиглэлд **387** хүн албан тушаал дэвшсэн





Premium Festival

Премиум корпорейшнийн бүх компаниудын нэгдсэн зуны хамгийн том эвэнт болох **“Premium Festival”** хөгжмийн наадам гайхалтай дурсамж дүүрэн болж өндөрлөлөө.

Бидний хамгийн эрхэм зүйл болох **Premium Family** хамт олон, залуус маань хамтдаа дуулж, бүжиглэж, амьд хөгжим сонсож, зуны нэгэн үдшийг гайхалтай өнгөрүүллээ.

Бүжгийн талбайн цангааг тайлах Чингис шар айраг, Asahi Super Dry бол энэ үдшийн салшгүй нэг хэсэг нь байлаа.





БИЗНЕС

CU конвиниенс дэлгүүр

Бусад охин компаниуд



Бизнесийн хандлага, ёс зүй

1

Онцлог, давуу тал

1

Стратегийн зорилтууд

1

Үйл ажиллагааны гүйцэтгэл

1



Бизнесийн хандлага, ёс зүй

Бидний арга барил

Бидний үндсэн бизнес	Бидний гол бизнесийн үйл ажиллагааны гол чиглэл болох хүнсний болон шингэн хүнсний жижиглэн худалдаа нь манай бизнесийн амжилтын үндэс суурь юм. Бид эдгээр бизнесээ стратегийн шууд хөрөнгө оруулалт ашиглан тасралтгүй хөгжүүлж, сайжруулахад тууштай ажиллаж байна.
Бэлэн байдал ба сэтгэл ханамж	Бид бизнесийн үйл ажиллагаагаа явуулахдаа гол анхаарлаа хандуулдаг хэсэг бол хэрэглэгчидтэй хамгийн ойр байх гол талуудыг хөгжүүлэхэд чиглэж ажиллах явдал юм. Энэ стратегийн чиглэлд төвлөрч ажилласнаар бид хэрэглэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлж, хэрэглэгчийн хэрэгцээг хангах зах зээлийн дүр төрхийг бий болгохыг зорьж байна
Арилжааны сэтгэхүй	Бид оновчтой арилжааны сэтгэлгээг бизнесийн өсөлтийг хангах, тогтвортой үргэлжлүүлэх гол чадвар гэж үздэг. Бизнесийн мэдрэмжийг бүхий л шийдвэртээ тусган ажилласнаар бид үйл ажиллагаагаа өрсөлдөх чадвартай, үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чиглүүлж, боломжийг илүү үр дүнтэй ашиглан хэрэглэгчдэдээ өндөр түвшний үйлчилгээг хүргэх боломжтой болно.
Уялдаа болон өсөлт	Бид үндсэн үйл ажиллагаатайгаа уялдаатай, өндөр синергитэй, өргөтгөх боломжтой бизнесүүдэд хөрөнгө оруулалт хийдэг. Стратегийн үнэ цэнэ бий болгох төслүүдэд төвлөрснөөр бид үндсэн бизнесийнхээ хөгжилд тууштай анхаарч, хөрөнгө оруулалтаа урт хугацааны өсөлтөд чиглүүлэн, хэрэглэгчдэдээ илүү үр дүнтэй үйлчлэх чадвараа бэхжүүлж байна.



Бизнесийн хандлага, ёс зүй

Бидний зарчим

Хэрэглэгч төвтэй	Бид хэрэглэгчдээ гүн гүнзгий ойлгож, тэдний хэрэгцээг хангаж, хүлээлтээс нь байнга давж ажиллахыг эрмэлздэг.
Арилжааны мэдрэмжтэй	Бид бизнесийн өсөлтийг дэмжих, тогтвортой байлгахын тулд стратегийн болон худалдааны сэтгэлгээг чухалчилдаг.
Өсөлтөд чиглэсэн	Бид ажилтнуудтайгаа хамт тасралтгүй суралцан, хөгжиж, өсөхийг хичээдэг бөгөөд урт хугацааны бизнесийн амжилтыг хангахын тулд харилцан хөгжлийг дэмждэг.
Хууль, эрх зүйн хүрээнд	Бид хууль дүрэм, журмыг чандлан сахиж ажилладаг.
Инновацлаг	Бид тасралтгүй өсөлтийн соёлыг эрхэмлэж, инновацыг дэмжин ажилладаг.
Хөгжлийг дэмжигч	Бид манлайллын чадварыг хөгжүүлэх, ажилтнуудын хөгжилд онцгой анхаарал хандуулдаг.



Үйл ажиллагааны онцлох давуу тал

Конвениенс сүлжээ дэлгүүр нь хэрэглэгчдийн хамгийн ойр байршилд, хэрэгцээтэй бүтээгдэхүүн, үйлчилгээг бүх цагт нээлттэйгээр тасралтгүй хангаж ажилладгаараа онцлогтой.

Премиум Нэкус ХК нь CU конвениенс дэлгүүрээр дамжуулан хэрэглэгчдийн өдөр тутмын амьдралд эрэлт хэрэгцээтэй бүтээгдэхүүн, үйлчилгээг хамгийн ойр байрлах ая тухтай орчинд 24 цагийн турш санал болгохыг зорьдог.

Бүтээгдэхүүн, үйлчилгээг тасралтгүй хүргэх, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг тогтмол өндөр түвшинд байлгахын тулд Премиум Нэкус ХК нь бүтээгдэхүүн, үйлчилгээний ялгарал, логикийн болон технологийн цогц шийдлийг бий болгож, нийгмийн дэд бүтцийн нэг хэсэг болж ажиллаж байна.

CU конвениенс дэлгүүр нь уламжлалт хүнсний дэлгүүр, мухлагтай харьцуулахад дараах 5 үндсэн онцлог давуу талтай:



Стратегийн зорилтууд



Зах зээлд манлайлах



Дэд бүтэц



Бүтээгдэхүүн, үйлчилгээний стандарт, ялгарал



Үнэнч хэрэглэгчдийг нэмэгдүүлэх



Технологийн дэвшлийг нэвтрүүлэх



Стратегийн зорилтууд



Зах зээлд манлайлах



Зах зээлийн тэлэлт

Улаанбаатар хот

24 цагийн үйлчилгээг хэрэглэгчдэд илүү ойртуулах зорилгоор Улаанбаатар хотын захын бүсүүдэд шинээр 15 дэлгүүрийг нээсэн.

Орон нутаг

Улаанбаатар хотоос 784 км зайд байрлах Ханбогд суманд CU дэлгүүрийн хамгийн хол салбарын нээлт хийгдсэн. Энэ дэлгүүр нь уул уурхай, аялал жуулчлалын чухал бүсүүд болон тэдгээрийн зам дагуу, Дундговь аймгийн Мандалговь сум, Өмнөговь аймгийн Даланзадгад, Цогц-Цэций сумуудад нийтийн ариун цэврийн өрөөтэй салбаруудаа нээгээд, дотоодын болон гадаадын зорчигчдын ая тух, гэнэтийн хэрэгцээг ханган үйл ажиллагаа явуулж байна.

Бусад чиглэлд Хэнтий аймгийн Цэнхэрмандал сум, Архангай аймгийн Хотонт сум, Өвөрхангай аймгийн Арвайхээр сум, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумуудад орон нутгийн зорчигчид түр амрах, бие засах боломжтой зам дагуух CU дэлгүүрүүдийг шинээр бий болгосон.

400 дахь салбар

CU конвинеиенс дэлгүүрийн мастер франчайз эрх эзэмшигч Премиум Нэксус ХК нь CU брэндийн 400 дахь салбар дэлгүүр Сэлэнгэ аймгийн Сүхбаатар суманд нээлээ.

Ингэснээр тухайн орон нутагт олон улсын үйлчилгээний стандартыг нэвтрүүлж, хүнсний аюулгүй байдлыг дээшлүүлэхээс гадна аялал жуулчлалын үйлчилгээний дэд бүтцийг сайжруулах, шинээр ажлын байр бий болгох, орон нутгийн бизнес эрхлэгчдийг дэмжих, эрүүл ахуй, орчны аюулгүй байдлыг сайжруулах зэрэг олон эерэг нөлөөг орон нутгийн хөгжилд авчирч байна.

Хэрэглэгчийн тоо (мянга)	2023	2024	Өсөлт
Улаанбаатар хот	43,257	54,212	25%
Орон нутаг	1,657	4,529	173%
Нийт:	44,914	58,741	31%

Дэлгүүрийн тоо	2023	2024	Өсөлт
Улаанбаатар хот	354	396	12%
Орон нутаг	20	49	145%
Нийт:	374	445	19%





Стратегийн зорилтууд



Зах зээлд манлайлах



Зах зээлийн тэлэлт

Дэлгүүрийн өнгө төрхийн сайжруулалт

Хэрэглэгчдэд илүү таатай орчин бүрдүүлэх, дэлгүүрийн өнгө төрхийг сайжруулах зорилгын хүрээнд, шинэ дэлгүүрүүдэд хана, шалны материалыг сүүлийн үеийн матт гадаргуу бүхий дизайнаар шинэчилж, илүү орчин үеийн, цэвэрхэн харагдахуйц заслын сайжруулалтыг хийсэн. Үүний зэрэгцээ хуучин дэлгүүрүүдийг ч мөн уг өнгө төрхийн дагуу засварлаж, сайжруулах ажлыг гүйцэтгэж байна.

Нийслэлийн болон орон нутгийн хэрэглэгчдийн гэнэтийн хэрэгцээ, шаардлагыг хангах зорилгоор 24 цагийн турш орох боломжтой ариун цэврийн өрөөний чанар болон хэрэглээг сайжруулах ажлын хүрээнд хуучин болон шинэ дэлгүүрүүдийн ариун цэврийн өрөөний тоноглолын стандартыг шинэчлэн сайжруулах хөрөнгө оруулалтыг хийж, илүү бат бөх, олон хүний эдэлгээ даахуйц ариун цэврийн өрөөг бий болгохын төлөө ажлыг эхлүүлсэн.





Стратегийн зорилтууд



Зах зээлд манлайлах



Франчайз бизнесийн үйл ажиллагаа

Бид 2018 оны 4-р сард БНСУ-ын конвiniенс дэлгүүрийн салбарт 30 гаруй жилийн туршлагатай, CU брэндийн эзэмшигч болон салбарын тэргүүлэгч Би Жи Эф Ритэйл компанитай мастер франчайзийн гэрээг байгуулж, Монгол Улсад CU брэндийн конвiniенс дэлгүүрийн үйл ажиллагааг эхлүүлсэн. Энэ нь худалдаа үйлчилгээний салбарыг нэг шат ахиулах чухал алхам болсон.

2020 оноос хувийн бизнестэй болох хүсэлтэй иргэд болон бизнесийн цар хүрээгээ тэлэх сонирхолтой жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулсан CU франчайз хөтөлбөрийг хэрэгжүүлэх болсон. Уг хөтөлбөрийн хүрээнд үйл ажиллагаа нь тогтворжиж, хэрэглэгчдэд танигдсан дэлгүүрүүдээс сонголт хийж, өөрийн бизнестэй болох боломжийг нээснээр CU франчайз эрх эзэмшигчдийн тоо өдрөөс өдөрт өсөн нэмэгдсээр байна.

2024 оноос хөдөө, орон нутагт салбаруудаа франчайз эрхээр нээн өргөжүүлж, илүү олон хүнд тогтвортой, ашигтай бизнесийн боломжийг санал болгож байна.

CU франчайз хөтөлбөрийн хүрээнд компани нь бүтээгдэхүүний ханган нийлүүлэлт, брэнд стандартын хянан нийцэл, дэлгүүрийн зөвлөх үйлчилгээ, маркетингийн үйл ажиллагаа, IT систем, сургалт зэрэг бүхий л төрлийн дэлгүүрийн дэмжлэг үйлчилгээгээр хангадаг. Харин эрх хүлээн авагч нь дэлгүүрийн удирдлагын үүргийг гүйцэтгэж, хамтарч ажилладаг.

Франчайз хөтөлбөрийг илүү олон жижиг дунд бизнес эрхлэгчид хүргэх, тэр дундаа эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор гуравдагч байгууллагуудтай хамтарсан зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд амжилттай нэвтрүүлээд байна. Тухайлбал, 2023 оны 5-р сард Зээлийн батлан даалтын сан, Капитрон банкттай хамтран НҮБ-ийн Тогтвортой Хөгжлийн 5-р зорилго буюу Жендерийн эрх тэгш байдлыг хангах, Эмэгтэйчүүдийн бизнесийн салбар дахь оролцоог нэмэгдүүлэх зорилгод нийцүүлэн эмэгтэй бизнес эрхлэгчдэд зориулсан батлан даалттай бизнесийн зээлийг жилийн 8.88%-ийн хүүтэйгээр авах боломжтой хамтын ажиллагааг эхлүүлээд байна.

🏠 73

Нийт Франчайз дэлгүүр

👤 63

Нийт Франчайз эрх хүлээн авагч

Хоёр дэлгүүртэй эрх хүлээн авагч 4
Гурван дэлгүүртэй эрх хүлээн авагч 2

💰 100%

Сургалтад хамруулж, сертификат олгосон

Ажилтнуудын ур чадварыг сайжруулахаас гадна хамтран ажилладаг франчайз бизнес эрхлэгчдэдээ дэлгүүрийн үйл ажиллагааг амжилттай удирдахад шаардагдах мэдлэг болон ур чадварыг ойлгох сургалтуудад хамруулдаг.

📈 27

Амжилттай зээлийн хүсэлт

Эмэгтэй бизнес эрхлэгчид уян хатан нөхцөлтэй, хамгийн бага хүүтэй зээлээр дэлхийн стандартад нийцсэн, шинэлэг, ая тухтай орчин бүхий CU конвiniенс дэлгүүрийг удирдан, хувийн бизнесээ эхлүүлэх боломжтой.



Стратегийн зорилтууд



Дэд бүтэц



Нийлүүлэлтийн гинжин хэлхээ

Нэгдсэн түгээлтийн төв нь CU конвинеиенс дэлгүүрийн дэд бүтцийн чухал хэсэг бөгөөд салбар дэлгүүрт борлуулагдаж буй нийт бүтээгдэхүүний 99% нь нэгдсэн түгээлтийн төвөөр дамжин хүргэгддэг. Эрүүл ахуйн өндөр хяналтын дор бүтээгдэхүүнүүдийг салбар дэлгүүрийн захиалгын дагуу бэлтгэж түгээлт, хүргэлтийн тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр салбар дэлгүүрүүдэд хүргэдэг. Хөлдөөсөн бүтээгдэхүүн, зайрмаг гэх мэт эмзэг, температурын нарийн горимд түгээгдэх шаардлагатай савласан бүтээгдэхүүнүүдийг хүйтэн түгээлтийн төвд төвлөрүүлж, мөн хөргөх болон хөлдөөх зориулалттай төхөөрөмжөөр тоноглогдсон тусгай тээврийн хэрэгслээр салбар дэлгүүрүүдэд түгээж байна.

Анализ &
Төлөвлөлт

Захиалга хүргэлт

Агуулах /
дүүргэлт

Хүргэлт


Дэлгүүр
хүлээн авах



Стратегийн зорилтууд



Бүтээгдэхүүн үйлчилгээний
стандарт, ялгарал





Бүтээгдэхүүн удирдлагын үйл ажиллагаа

- Хэрэглэгчдэд аль хэдийн танигдсан, зах зээлд эрэлттэй бүтээгдэхүүнийг гадаадын болон дотоодын нийлүүлэгчээс хүлээн авч борлуулж байна.
- Шинэ хэрэглээг бий болгох зорилгоор дотоодын үйлдвэрлэгч компаниудтай хамтран хөгжүүлэлт хийж, зах зээлд шинэлэг, тренди бүтээгдэхүүнийг нэвтрүүлж байна.
- Олон улсад тренд болж буй шинэлэг бүтээгдэхүүнүүдийг албан ёсны онцгой эрхтэйгээр импортолж, үйл ажиллагаа явуулж байна

Нийлүүлэгчийн харьцаа

Дотоодын
үйлдвэрлэгч

Импортын
бүтээгдэхүүн
нийлүүлэгч



6397
нэр төрөл



507
нийлүүлэгч



2024 онд нийт **6397** нэр төрлийн бүтээгдэхүүнийг **507** нийлүүлэгчээс худалдан авч борлуулсан

Онцлох бүтээгдэхүүн



Шөлтэй хоол

Монголчуудын хамгийн их иддэг шөлтэй хоолны төрлүүд болох Жигнэсэн гурилтай шөл, Кимчи жигэ, Тактуритан зэрэг бүтээгдэхүүнийг хачир болох будаа, гурилтай нь хамт савлаж, хүйтний улиралд хэрэглэгчдэд санал болгож байна. CU конвиниенс дэлгүүрээс шөлтэй хоолыг хялбархан худалдан авч, хэрэглэх боломжийг олгосноор манай бүтээгдэхүүн олон давуу талтай болсон.



CUPBAR

Нэг аяганаас олон төрлийн амтны хослолыг ХУТГААД АМТЛАХ боломжтой 3 төрлийн cupbar бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлээ.

Энэ бүтээгдэхүүн нь хэрэглэгчдийн худалдан авдаг TOP бүтээгдэхүүнүүдийн нэг болж, Солонгос маягийн амт, орцтой гэдгээрээ онцлогтой.



Odeng / Үдэн

CU конвиниенс дэлгүүр нь Солонгосын алдартай street food-ийн нэг болох үдэнийг 20 салбараараа санал болгож эхэлсэн. Хүйтний улиралд дулаацаж, амттай шөл уух хүсэлтэй хэрэглэгчдэд энэ бүтээгдэхүүнийг санал болгож байна.

Салбарын тоог нэмэгдүүлж, илүү олон хэрэглэгчдэд хүргэхээр зорьж байна.

Онцлох бүтээгдэхүүн



NEW SIZE KIMBAB

Хэрэглэгчдийн таньж мэддэг кимбаб буюу будааны ороомгийн хэмжээ шинэчлэгдэж, шинэ төрөл нэмэгдлээ. Шанзны хэмжээ ихсэж, амт илүү сайжирсан. Сав баглаа боодлын өнгө, загвар ч мөн шинэчлэгдлээ.



Шимт цуврал

Монгол үндэстний хэрэглэж заншсан 5 цулын махаар бүрдсэн Хөвсгөр бууз, Шимт хуурга, НМР шөл зэрэг бүтээгдэхүүнээс бүрдсэн энэ цувралыг нэвтрүүлээ. 5 цул нь эрүүл мэндийн олон давуу талтай бөгөөд намар, өвөл, хаврын улиралд дотоод тамир сэргээж, амин дэм, шимийг хүртээх зорилгоор орчин үеийн амталгаатайгаар хөгжүүлсэн бөгөөд хэрэглэгчдэд санал болгож байна.

Энэхүү цуврал бүтээгдэхүүн нь салбарт болон гэртээ, хаана ч идэхэд тохиромжтой.



Шарсан тахиа

2024 оноос эхлэн шарсан тахиа болон шарсан төмсний шинэ төрлүүдийг 100 салбар дэлгүүрээр дамжуулан хэрэглэгчдэд санал болгож байна. Эдгээр бүтээгдэхүүнүүд нь халуун, шинэхээрээ хэрэглэгчдэд хүрч, хэрэглэгчдэд тав тухтай сонголтуудыг нэмэгдүүлэхэд чиглэсэн болно.

Мөн түүнчлэн, бүх салбарт шортой шарсан тахианы төрлийг хэрэглэгчдэд санал болгож эхлээд байна.



Онцлох бүтээгдэхүүн



Боазза /Хөвсгөр бууз/

Пицца болон хөвсгөр буузыг хослуулсан Европ болон Ази амтыг нэгтгэсэн БОАЗЗА мэндэллээ.

10 жилийн сурагчдаас эхлээд бүх насныхны сонирхож хэрэглэх бяслагаар баялаг шинэ Хөвсгөр бууз.



Корокке

Ширхгийн хоолны сонголтыг өргөжүүлэх зорилгоор 2 төрлийн амттай шарсан короккег нэмж орууллаа.

Азийн амт шингэсэн, баялаг орцтой, хэрэглэгчдийн сонирхлыг татахуйц короккег амжилттай хөгжүүлж, нэвтрүүлээ



Жэюүгтэй Хөвсгөр бууз

Монгол хэрэглэгчдийн дуртай амтны нэг болох Жэюүг – халуун ногоотой гахайн махан шанзтай хөвсгөр бууз.

Шинэ төрлийн амтаар ХӨВСГӨР БУУЗ бүл нэмж, хэрэглэгчдэд санал болгож эхлэв.

Онцлох бүтээгдэхүүн



Таиуаки – Загасан жигнэмэг

Азийн орнуудад алдартай загасан жигнэмгийг халуунаар нь санал болгож эхлэв. Зөөлөн, халуун жигнэмэг нь дотроо кастард кремтэй бөгөөд ямар ч үед идэхэд тохиромжтой..



Хоол хялбаршуулах хөлдөөсөн бэлдэц

Сүүлийн жилүүдэд дэлхийн зах зээлд тренд болоод буй цаг зав хэмнэж, хоол хялбаршуулах бүтээгдэхүүнийг хөгжүүлэн орон сууцны бүсийн салбаруудаар борлуулж эхлэв.

Хамгийн ихдээ 30 минутад бүгд бэлэн болох хялбаршуулсан бэлдэц бүхий энэхүү бүтээгдэхүүнийг цөөн бүлтэй, цаг завгүй гэр бүлүүдэд зориулан нэвтрүүлээ.



VEGAN Bakery

Веган буюу амьтны гаралтай орц найрлага агуулаагүй төрөл бүрийн жигнэмэг, бэйкери бүтээгдэхүүнийг зөвхөн CU-н хэрэглэгчдэд зориулан нэвтрүүлэв.

Онцлох бүтээгдэхүүн



Betty Mini cakes

Баялаг амттай, жижиг хэмжээтэй гурилгүй бялууны төрлүүдийг зөвхөн CU-р борлуулж эхлэв. Кофетой болон хоолны дараа идэхэд төгс тохирсон бүтээгдэхүүн.



Yonsei Match cream bun

Солонгост борлуулалтаараа тэргүүлж, хэрэглэгчдийн дунд тренд болоод буй Yonsei Cream Bun-ы шинэ төрөл болох Матча / Ногоон цайтай төрлийг нэвтрүүлэв.



GET Matcha latte

Хэрэглэгчдийн дунд ногоон цай, матчаны хэрэглээ өссөнтэй холбоотой шинэ төрлийн матчатай кофе болон энгийн матча латте санал болгож эхлэв.



Онцлох бүтээгдэхүүн



Sliced cake

Кофетой хослох илүү эрүүл орц найрлага бүхий бэйкери төрлүүдийг нэмлээ.

Жижиг хэмжээтэй бөгөөд CU-с аваад хаана ч идэхэд хялбар бүтээгдэхүүн юм.



Шингэн сүүтэй Mocha

Шингэн сүүтэй, машинаас шууд гарах шоколадтай кофе буюу Mocha-г нэвтрүүлэв.



KitKat

KitKat шоколадны өвөрмөц амттай төрлүүдийг Япон улсаас импортлон 2024 оны 10-р сараас эхлэн зөвхөн CU сүлжээ дэлгүүрээр борлуулж эхэллээ.



Онцлох бүтээгдэхүүн



Baskin Robbins

Baskin Robbins брэндийн амны зугаа болон шоколадыг Солонгос улсаас импортлон 2024.07 сараас худалдаалж байна.



Японы Lotte брэндийн бүтээгдэхүүнүүд

Японы Lotte брэндийн бүтээгдэхүүнүүдийг 2023 оноос хойш албан ёсны эрхтэйгээр худалдаалж байгаа ба 2024 оны 12 сард хүүхдэд зориулсан сахаргүй, жижиг савлагаатай бүтээгдэхүүн импортлон оруулж ирлээ. Мөн 2024 оны 10 сараас албан ёсны дистрибьюторын эрх авах хэлэлцээр эхэлсэн



Японы Lotte брэндийн зайрмаг

Японы Lotte брэндийн зайрмагийн нэр төрлийг төрөлжүүлэн оруулж ирдэг бөгөөд 2024 оны 4-р сард сахаргүй мөсөн зайрмаг оруулж ирсэн бол, 2024 оны 12-р сард АНУ болон Шинэ Зеланд улсууд руу гаргадаг 9 төрлийн гэр бүлийн зайрмагийг оруулж ирсэн.

Онцлох бүтээгдэхүүн



Жинхэнэ АМЬД ШАР АЙРАГ Limited edition

Chinggis брэндийн амьд шар айргийг одоо хүссэн газраа амтлан уух боломжтой боллоо. 2 литрийн савлагаатай тус бүтээгдэхүүн нь Зөвхөн CU сүлжээний сонгосон салбаруудаар худалдаалагдлаа. Чанарыг эрхэмлэгч бүх хүнд зориулсан, онцгой бүтээгдэхүүн юм.



ASAHI NAMA JOKKI шар айргийн шинэчлэл, инновацийн гайхамшиг!

Лаазалсан драфт шар айраг нь задгай шар айргийн амтыг хүссэн үедээ, хүссэн газартаа амсах боломжийг олгож байна. Таг нь бүтэн нээгддэг энэхүү драфт шар айраг нь онцгой мэдрэмж, таашаалтай амтыг хайж буй бүх хүнд зориулсан бүтээгдэхүүн юм.

Онцлох бүтээгдэхүүн



Lemon Highball 500ml

Солонгос улсад тренд болж буй бүтээгдэхүүн юм. Бүтээгдэхүүн нь дотроо лимоны зүсэмтэй ба бага градустай, амттай мэдрэмжийг өгч, хөнгөн хөгжилдөхийг хүссэн залууст зориулсан бүтээгдэхүүн юм.



CASS

CASS брэндийн шинэ өнгө төрх, Lemon Cass Squeeze нь лимонд дурлагчдад зориулсан лимоны амттай пиво юм. Энэ бүтээгдэхүүн нь зөвхөн CU сүлжээгээр борлуулагдаж байгаа ба жимсний амттай, зөөлөн пивонд дурлах хүн бүхэнд зориулсан сонголт юм.



KELLY Lager

БНСУ-ын 100 жилийн түүхтэй Hite-Jinro компанийн шилдэг бүтээгдэхүүн KELLY Lager шар айраг Монголд CU сүлжээгээр анхлан нэвтэрлээ. Давхар исгэлтийн технологиор үйлдвэрлэгдсэн энэхүү пиво нь зөөлөн хэр нь хүчирхэг амттай. Шар айрганад дурлагч хүн бүхэнд зориулсан төгс амттай бүтээгдэхүүн юм.

Онцлох бүтээгдэхүүн



NFC

Хятад улсын ус ундаагаар тэргүүлэгч Nongfu брэндийн 100% шүүсийг импортлон худалдаалж эхэллээ. Тус шүүс нь тариалангийн талбайгаас шууд шахаж савлагддаг бөгөөд хадгалах хугацаа 4 сар юм.



Starbucks

Америкийн нэгдсэн улсын №1 Starbucks брэндийн кофе Солонгосоос импортоор авч, борлуулж эхэллээ.



Cantata

Лотте брэндийн лаазтай кофе Cantata-г Солонгос улсаас импортлон дулаан баригч болон хөргүүрт байршуулан борлуулж эхэллээ.



Стратегийн зорилтууд



Үнэнч хэрэглэгчдийг
нэмэгдүүлэх



CU аппликэйшны боломжууд

Үнэнч хэрэглэгчийн хөтөлбөр нь хэрэглэгчийг лояалти оноогоор шагнах, худалдан авалтын давтамжид суурилсан урамшуулал олгох, олон төрлийн дижитал үйлчилгээг санал болгох замаар урт хугацаанд хэрэглэгчдэд өгөх үнэ цэнийг нэмэгдүүлдэг бөгөөд CU аппликэйшнээр дамжуулан тус хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

2024 оны 12-р сарын байдлаар CU
аппликэйшн хэрэглэгчийн үзүүлэлт:

Хэрэглэгчийн тоо	Хэрэглээний тоо
CU аппликешн хэрэглэгч	1 сая
Идэвхтэй хэрэглэгч	269,723
Ebarimt холбосон хэрэглэгч	222,295
Төлбөрийн баримтыг автоматаар бүртгэсэн	8.6 сая

CU аппликэйшн хэрэглэгчдэд илүү үнэ цэнийг үүсгэх зорилгоор гуравдагч байгууллагуудтай хамтарсан дижитал үйлчилгээнүүдийг нэвтрүүлээд байна.

Үүнд:

Дэлгүүрийн байршлыг газрын зураг дээрээс олон төрлөөр шүүж харах:

Хэрэглэгч CU аппликэйшн дотроос өөрт хамгийн ойр байрлах CU дэлгүүрүүдийн хаяг байршлын мэдээллийг харах боломжтойгоос гадна 24 цагийн салбар, архи тамхи худалдаалдаг салбар, powerbank-тай салбаруудыг шүүн харах боломжтой болсон.

Бүтээгдэхүүн, үйлчилгээг сайжруулах зорилгоор хэрэглэгчээс санал асуулга авах:

Хэрэглэгчдийнхээ санал сэтгэгдлийг сонсох зорилгоор 2023 оны 2-р сараас эхлэн CU аппликэйшнээр дамжуулан бүтээгдэхүүний амт чанарын судалгаа болон NPS (Net Promoter Score) судалгааг тогтмол авч байна.

2023 онд 96,633 хэрэглэгчээс NPS судалгаа болон 100 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүний сэтгэл ханамжийн судалгааг авч, судалгааны үр дүнд үндэслэн бүтээгдэхүүн үйлчилгээний чанараа үе шаттайгаар сайжруулан ажилласнаар хэрэглэгчийн сэтгэл ханамж 2022 онтой харьцуулахад 17%-иар өссөн үзүүлэлттэй байна.

CU Кредит картаар худалдан авалт хийх:

Санхүүгийн тулгамдсан хэрэгцээ үүссэн үед CU-ээс хэрэгцээт бүтээгдэхүүнийг зээлээр авах боломжийг олгох зорилгоор Голомт банктai хамтарсан CU Кредит картыг 2023 оны 6-р сард хэрэглээнд амжилттай нэвтрүүлээд байна. 2024 оны байдлаар 9,296 хэрэглэгч CU Кредит карт эзэмшигч болж 44,602 удаа зээлээр худалдан авалт хийсэн байна. Цаашид зээлийн карт эзэмшүүлэх шалгуурыг уян хатан болгож, үйлчилгээний нөхцөлийг сайжруулж, Кредит картын хүртээмжийг нэмэгдүүлэхээр зорин ажиллаж байна.

Банкны картаа холбож аппликэйшн дотроосоо төлбөр төлөх:

Хэрэглэгчдийн худалдан авалтын процессыг илүү хөнгөвчлөх зорилгоор CU аппликэйшнд банкны картаа холбох функцийг нэвтрүүлж, аппликэйшн дотроос төлбөр төлөх боломжийг бүрдүүлсэн. Ингэснээр нэг хэрэглэгчид үйлчлэх хугацаа 2 дахин багасаж хэрэглэгчдэд хурдан шуурхай үйлчилгээ үзүүлж байна.



Онцлох үйл явдлууд

Mega ball



Megaball лотерей нь Улаанбаатар хот дахь CU конвiniенс дэлгүүрийн 100 салбараар биет тасалбарыг борлуулж эхэллээ. Megaball нь Монголын анхны нэг тэрбум төгрөгийн шагналын сантай лотерей бөгөөд оролцогчид лотерейн зургаан тоог автоматаар сонгох, эсвэл өөрөө бөглөх сонголттой гэдгээрээ онцлог юм.

UMoney



2024 оны 04 дүгээр сараас эхлэн CU-гийн 250 салбараас Umoney картыг худалданавах, цэнэглэх боломжтой болсон. Карт худалданавах, цэнэглүүлэхдээ төлбөрөө бэлэн мөнгө эсвэл банкны картаар төлөх боломжтой.



Стратегийн зорилтууд



Технологийн дэвшлийг
нэвтрүүлэх

CU орохдоо CU Pay-ээр төлье

CU конвиниенс дэлгүүр хэрэглэгч үйлчлүүлэгчид дээ зориулан хамгийн хялбар төлбөрийн шийдэл CU Pay үйлчилгээг албан ёсоор нэвтрүүллээ.

CU Pay нь хэрэглэгч танд Alipay болон WeChat Pay-тэй адил шинэ үеийн төлбөрийн шийдлийг санал болгох бөгөөд хэрэглэгч та ердөө Ганцхан үйлдлээр төлбөр төлөх, урамшууллын оноо цуглуулах, цаас хэвлэхгүй цахим баримт авч илүү байгальд ээлтэй хэрэглэгч байх боломжийг олгож байна.

Ганцхан үйлдлээр CU Pay үйлчилгээг ашиглахын тулд:

Хэрэглэгч та CU аппликейшн дээрээ E-Баримтын бүртгэлээ холбоод CU конвиниенс дэлгүүрээс худалдан авалт хийх бүртээ цахим баримт хүлээн авч, цаасан баримт хэвлүүлэх шаардлагагүй болно. Ингэснээр та жилд нэг тонн цаас хэмнэнэ.

Худалдан авалт хийхдээ CU аппликейшн ашиглан оноо цуглуулах, төлбөр төлөх, цаасан eBarimt хэвлэн авах зэрэг үйлдэлд дундажаар 30-45 секунд зарцуулдаг. Харин CU Pay төлбөрийн хэрэгслийг ашигласнаар эдгээр бүх үйлдлийг ганцхан үйлдлээр хийх боломжтой боллоо. Ингэснээр хэрэглэгч ердөө 3-5 секундын дотор худалдан авалт хийж 10 дахин хурдтай үйлчлүүлэх боломжтой.

CU Pay нь таны өдөр тутмын худалдан авалтыг хялбаршуулж, цаг хэмнэхээс гадна сар бүр танд зориулсан тусгай хөнгөлөлт, урамшуулал, мөн үнэнч хэрэглэгчийн онооны урамшууллыг санал болгох юм.



Лоялти Маркет



CU апп-ны үнэнч хэрэглэгчдэд зориулсан хамгийн гоё, супер хямдралтай цэс – Loyalty Market!

Цуглуулсан оноогоороо олон төрлийн барааг зөвхөн CU апп-тай хэрэглэгчдэд зориулсан 60%-ийн хямдралтай үнээр авах боломжтой Долоо хоног бүр шинэ бүтээгдэхүүн нэмэгдэж, бэлэг барих болно.



1 оноо = 1 төгрөг

учраас оноогоо цуглуулж, хүссэнээ хялбархан аваарай!



Үйл ажиллагааны гүйцэтгэл


▲ Цэвэр борлуулалт /тэрбум төгрөг/






Үйл ажиллагааны гүйцэтгэл


Ажиллагсдын тоо




Татвар төлөлт (тэрбум төгрөгөөр)



Нийт сүлжээний борлуулалт (тэрбум төгрөгөөр)



Үйлчлүүлэгчдийн тоо (сая)





БИЗНЕС

CU конвиниенс дэлгүүр

Бусад охин компаниуд

Сэнтрал Фүүдс ХХК 1

Сэнтрал Кофе Рөүстинг ХХК 1

Сэнтрал Коммерс ХХК 1

Чингис Шар Айраг ХХК 1

Премиум Нэксус Ложистикс ХХК 1

Стора Централ ХХК 1



Олон улсын стандартад нийцсэн хоол үйлдвэрлэл

Премиум Нэксус ХК нь CU сүлжээний бүх салбарт өдөр бүр эрүүл, аюулгүй хоолыг үйлдвэрлэн хүргэх зорилгоор 2020 оны 11-р сард Баянзүрх дүүргийн Хонхор тосгонд 2,600м² талбайтай CU хоолны үйлдвэрийг ашиглалтад оруулсан.

Улмаар 2022 онд үйлдвэрлэн гаргасан бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг баталгаажуулах, олон улсын стандарт шаардлагад нийцүүлэх зорилгоор Аюулын дүн шинжилгээ ба Эгзэгтэй цэгийн хяналтын (Hazard Analysis Critical Control Point) болон Үйлдвэрлэлийн зохистой дадлын (Good Manufacturing Practice) тогтолцооны болзлыг хангаж, албан ёсоор сертификатжсан Монголын анхны нэг чигийн урсгалтай хоолны үйлдвэр болов.

Тус хоолны үйлдвэр нь өдөр бүр 30 орчим нэр төрлийн 50 мянган ширхэг хоолыг хүнсний хугацаа уртасгагч, тогтворжуулагч бодисгүйгээр үйлдвэрлэж байна. Мөн жижиг дунд бизнес эрхлэгчдэд CU хоолны үйлдвэрийн дэд бүтэц, ажиллах хүчинд түшиглэн бүтээгдэхүүн хөгжүүлэх, CU конвинеенс дэлгүүрээр борлуулах боломжийг нээсэн билээ. Тус үйлдвэрийн барилгын давуу тал нь хүнсний үйлдвэр болон хөргөх өрөөг зориулалтын EPS, полиуретан хавтангаар дугуй булан гарган хийсэн нь нян бактери үржихгүй байх нөхцөлийг бүрдүүлсэнд оршдог.

Дэлгүүрийн тэлэлттэй уялдуулан үйлдвэрийн бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хөдөлмөр хөнгөвчилсөн автоматажсан шугамуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсээр ирсэн. 2024 оны хувьд дараах томоохон хөрөнгө оруулалтыг хийж чанар эрүүл ахуйг хангаж бүтээмжийг нэмэгдүүлсэн.

- Япон улсын бүрэн автомат 26м урттай цагт 900кг агшаах хүчин чадалтай будаа боловсруулах шугам
- Герман улсын савтай хоолыг азот нүүрсхүчлийн хийгээр савлах цагт 1300ш хоол савлах хүчин чадалтай Multivac брэндийн шугам
- Цагт 1800ш савлах хүчин чадалтай Кимбабны шугам

зэргүүдийг үйлдвэрлэлд нэвтрүүлсэн. Ингэснээрээ бүтээгдэхүүний чанар сайжрах, гарцыг нэмэгдүүлэх, хүнээс хамааралтай технологи ажиллагааны алдааг бууруулах зэрэг олон давуу талыг бий болгож байна.

Үйлдвэрлэлийн чанар, аюулгүй байдлыг сайжруулах үүднээс бид олон улсын Чанарын менежментийн тогтолцоо (MNS ISO 9001:2016), Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо (MNS ISO 22000:2019), Байгаль орчны менежментийн тогтолцоо (MNS ISO 14001: 2019) гэсэн стандартуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж чадсан. Мөн 2025 онд MNS ISO 17025:2017 лабораторийн олон улсын стандартыг авахаар зорьж үйл ажиллагаандаа төлөвлөн ажиллаж байна.

Сэнтрал Фүүдс ХХК

CU хоолны үйлдвэр нь нэгдсэн стандартын болон бүтээгдэхүүн үйлчилгээний баталгаажуулалтын тохирлын гэрчилгээг гардан авлаа

1. MNS ISO 9001:2016,
2. MNS ISO 22000:2019,
3. MNS ISO 14001:2016,
4. MNS CAC RCP 1:2023
5. MNS 4946:2019

2025 онд авахаар зорьж буй стандартууд

6. MNS ISO 17025:2017 Олон улсын Сорилтын болон шалгалт тохируулгын, лабораторийн чадавхад тавигдах ерөнхий шаардлага



Нийт 5 стандартыг баталгаажуулсан анхны хоол үйлдвэрлэлийн байгууллага боллоо.




Бэлэн бүтээгдэхүүн



14.4 САЯ ширхэг

2024 онд 14,4 сая ширхэг бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн бөгөөд 2025 онд 21,5, сая ширхэг бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхээр зорин ажиллаж байна.

Нэг цагт үйлдвэрлэх
кимбаб



1800 ширхэг

Шинэ кимбаб шугам ашиглалтад оруулснаар чанар болон бүтээмжийг сайжруулсан.

Нэг цагт савлах
савтай хоол



1300 ширхэг

Мултавак автомат бэнто хоол савлагч шугам

Үйлдвэрлэлийн бүтээмж



+50% нэмэгдсэн

Өмнөх онд 1 хүн цагт 40,2ш бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг байсан бол 2024 онд 60,6ш болж бүтээмж 50%-р нэмэгдсэн

Нэг цагт 900кг
будаа



X5 нэмэгдсэн

26м урт өндөр хүчин чадалтай бүрэн автомат будааны шугамтай болсон.

Налайх дүүргийн
ажилтан



133

Налайх дүүргээс нийт 133 ажилтан ажиллаж байгаа бөгөөд үүний 7 ажилтан нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна.



Сэнтрал Кофе Рөүстинг ХХК

Сэнтрал Кофе Рөүстинг ХХК нь 2023 онд үүсгэн байгуулагдсан ба СУ сүлжээ дэлгүүрээр зарагддаг аягатай кофены хуурсан үрийг хуурч савлан нийлүүлэх болон хэрэглэгчдэд шууд хэрэглэх боломжтой савласан бүтээгдэхүүнийг нийлүүлэх үйл ажиллагааг эрхэлж байна. Шинэ ургацын кофены ногоон үрээ түүхий эдийн чиглэлийн арилжаагаар тэргүүлэгч Louis Dreyfus компаниас авч кофе хуурагч машин үйлдвэрлэлээр тэргүүлэгч Probat компанийн тоног төхөөрөмжөөр кофегоо хуурч хэрэглэгчдэд хүргэж байна. Мөн тус хуурах технологи дээр Герман улсад сургалтад суусан мэргэжлийн баг ажиллаж байна



Ногоон үр

Шинэ ургацын чанартай ногоон кофены үрийг гарал үүслээс нь импортлон оруулж ирдэг.



Герман технологи

Дэлхийн шилдэг Герман технологиор эх орондоо хуурч савлан кофегоо гаргаж байна.



СУ болон Нoreca

СУ-гийн 445 салбар дэлгүүрээр хэрэглэгчдэд хүргэхээс гадна Хорека зах зээл рүү амжилттай нэвтэрч 86 харилцагчтай болсон.



Кофены машин

Дэвшилтэт технологи бүхий Кофе машиныг шууд болон түрээсээр авах үйлчилгээг харилцагч нартаа санал болгож байна.



Сэнтрал Коммерс ХХК

Сэнтрал Коммерс ХХК нь CU конвинеенс дэлгүүртэй хамтран ажиллах чадвартай, дэлхийн алдартай FMCG (Fast-Moving Consumer Goods) бүтээгдэхүүнүүдийг борлуулалтын бүх сувагт хүргэх импорт, маркетинг болон түгээлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

2023 онд Asahi Beer Asia Limited компанитай албан ёсны хамтын ажиллагааны гэрээ байгуулагдаж, 2024 онд борлуулалтын сувгуудаа өргөнөөр тэлж, Asahi Super Dry шар айргийг Монголын 21 аймагт борлуулж эхэлсэн. Ирээдүйд бид хамтын ажиллагаагаа өргөжүүлэн, бусад дэлхийн алдартай шар айраг болон ундаа бүтээгдэхүүнийг оруулж ирэхээр төлөвлөж байна



Үйл ажиллагаагаа нэгтгэв

2024 оны 7-р сараас эхлэн Сэнтрал Коммерс компани нь Чингис шар айргийн борлуулалт, түгээлт болон маркетингийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж эхэлсэн.



Шинэ савлагаа

Чингис шар айраг хэрэглэгчдэд хүртээмжтэй байдлаар санал болгохын тулд 2 литрийн шинэ савлагааг зах зээлд амжилттай нэвтрүүлж, CU салбаруудад борлуулалт эхлүүлсэн



Лоялти систем

Сэнтрал Коммерс компани харилцагчийн лоялти системийн төслийг хэрэгжүүлэх ажлын I-р үе шатыг амжилттай зохион байгуулж, харилцагчдадаа урамшууллын хөтөлбөрийг санал болгож эхэлсэн.



On Trade

2024 онд хорека зах зээлд задгай шар айргаа тогтмол түгээсээр, нийт 344 харилцагчидтай болж, үйл ажиллагаагаа амжилттай явуулж байна



Asahi Super Dry “Cherry blossom”

Cherry blossom limited edition бүтээгдэхүүнээ зах зээлд танилцууллаа.



Зах зээлийн тэлэлт

Asahi Super Dry нь 2024 оны 5-р сараас эхлэн 21 аймагт албан ёсоор борлуулагдаж эхэллээ.



Asahi Super Dry “Nama Jokki”

2024 оны 11-р сараас эхлэн орчин үеийн шинэчлэл инновацыг өөртөө агуулсан лаазтай драфт шар айргийн төрлийг танилцууллаа.



Asahi Super Dry Draught

2024 оны 11-р сараас эхлэн Asahi Super Dry драфт шар айргийг зах зээлд нэвтрүүллээ.



Чингис Шар Айраг ХХК

Чингис Шар Айраг ХХК нь 1997 онд үүсгэн байгуулагдсан ба Монгол Улсын шар айраг үйлдвэрлэлийн салбарт 'Чингис Шар Айраг' брэндийг амжилттайгаар таниулсан үндэсний шилдэг аж ахуйн нэгж юм. Европын чанартай түүхий эдийн найдвартай ханган нийлүүлэгчидтэй олон жилийн турш хамтран ажилласнаар, пилснер буюу зөрөг цэцгийн хандтай, гашуувтар, шүүлтүүртэй, тунгалаг, сэнгэнэсэн амттай шар айргийг чанарын өндөр түвшинд үйлдвэрлэн борлуулж байна.

Чингис Шар Айраг ХХК нь жилд 1.5 сая литр шар айргийг үйлдвэрлэж нийлүүлэх хүчин чадалтай бөгөөд цаашид амт, чанар, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлж, олон төрлийн савлагаатайгаар хэрэглэгчдэд хүргэх зорилготой.

Мөн шар айргийн үйлдвэрлэлээс гадна, Улаанбаатар хотод нийтийн хоолны үйлчилгээний салбарт 'Чингис Шар Айраг Клуб' ХХК үйл ажиллагаагаа амжилттай явуулж байна.





Премиум Нэксус Логистикс ХХК

Премиум Нэксус Логистикс ХХК нь 2024 оны 10-р сараас CU конвинеенс дэлгүүртэй хамтран ажиллахад бэлтгэгдэж, нэгдсэн түгээлтийн төв болон хүйтэн хэлхээ агуулахын үйл ажиллагааг тээвэр, түгээлтийн үйлчилгээтэй хамт хариуцан гүйцэтгэж байна. Бид цаашид олон улсын стандартын дагуу логистикийн үр дүнтэй шийдлийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн, эдийн засгийн хувьд үр ашигтайгаар үйлчилгээ үзүүлж, үйлчлүүлэгчдийн амжилтад хувь нэмэр оруулах зорилготой байна.



Түгээлтийн төв

Түгээлтийн төв нь хуурай түгээлтээр 550 дэлгүүрийн захиалгыг бэлтгэдэг хүчин чадалтай. Мөн нийт 6220 мкв талбайд 140 ажилтантайгаар, үр бүтээлтэй үйл ажиллагаа явуулж байна.



Хүйтэн хэлхээ агуулах

Хүйтэн хэлхээний агуулах нь 609 дэлгүүрийн захиалгыг бэлтгэн гаргах чадалтай. Агуулах нь нийт 1000 мкв талбайг хамардаг ба 84 ажилтантайгаар амжилттай үйл ажиллагаа явуулж байна.



Тээвэр, түгээлтийн үйлчилгээ

Түгээлтийн төвүүдээс бэлтгэн гаргасан бараа бүтээгдэхүүнийг зориулалтын температурын нөхцөлд тээвэрлэх зориулалттай тоноглолтой ISUZU

брэндийн 70 автомашиныг худалдан авсан. Мөн, туслан гүйцэтгэгчийн 100 гаруй тээврийн хэрэгслийг энэхүү 70 автомашинаар орлох чадалтай байна.



Стора Централ ХХК

Стора Централ ХХК нь Монголын зах зээлд кросс бордер и-коммерс үйлчилгээг технологи болон тээвэр логистикийн цогц шийдлээр санал болгодог платформуор дамжуулан өргөн хүрээний бараа бүтээгдэхүүнийг худалдан авах боломжийг олгодог.

Компанийн зүгээс дэлхийд онлайн худалдааны салбарт тэргүүлэгч Америкийн Амазон, Хятадын Таобао гэсэн хоёр том онлайн худалдааны платформуос бараа бүтээгдэхүүн захиалах боломжийг санал болгож байсан. 2024 оны 9-р сард Stora V2.0 хувилбараа танилцуулж, хэрэглэгчдийн гар дээр олон шинэ боломжуудыг бий болгосон бөгөөд гадаад улсаас захиалсан бараа бүтээгдэхүүнийг CU сүлжээ дэлгүүрийн салбар руу хүргэх үйл ажиллагааг явуулж эхэлсэн.

Стора Централ ХХК нь 2024 оны 12-р сарын байдлаар 90,000 бүртгэлтэй хэрэглэгчтэйгээр амжилттай үйл ажиллагаа явуулж байна.

Энэхүү шинэчлэлийн хүрээнд Монголын хэрэглэгчид Стора платформуор дамжуулан дараах боломжуудыг ашиглах боломжтой болов:

- Бүх төрлийн барааг олох боломжтой Америкийн eBay платформ.
- Ахуйн барааг хамгийн ихээр худалдан авдаг Costco.
- Шинэ загваруудыг цаг алдалгүй авах боломжийг хангах зорилгоор Apple.
- Томоохон гоо сайхны брэндүүдийн хамгийн чанартай бүтээгдэхүүнийг санал болгодог Sephora.
- Дэлхийд гарсан шинэ загварыг хүлээлгүй авах боломжийг бүрдүүлж буй Nike.
- Шведийн алдарт IKEA брэндийн бүтээгдэхүүнийг хамгийн хямдаар авах боломжийг олгож буй V2.0 платформ.

Эдгээр боломжууд нь технологи, тээвэр, захиалгын зөвлөх үйлчилгээний цогц системийг шинэчлэгдсэн V2.0 дээр холбосноор хэрэглэгчдэд илүү хялбар, үр дүнтэй худалдан авалтыг санал болгож байна.





eBay


eBay нь Америкийн томоохон онлайн худалдааны платформ бөгөөд Стора-ийн технологийн шийдлээр холбогдсоноор тус платформ дээр борлуулагдаж буй 1.7 тэрбум гаруй бүх төрлийн бараа бүтээгдэхүүнээс худалдан авах боломжийг Монголын хэрэглэгчдэд олгож байна.

eBay платформ нь хаанаас ч олддоггүй эртний эдлэл, ховор сонин бараа, машины сэлбэг, технологийн бүтээгдэхүүн, төрөл бүрийн цуглуулга зэрэг онцгой бүтээгдэхүүнүүдийг санал болгодгоороо онцлогтой. Энэ нь хэрэглэгчдэд өргөн сонголт, өвөрмөц туршлага санал болгож, онцгой хэрэгцээг хангах боломжийг бүрдүүлж байна.

JD.com (Жингдунг)

JD.com (Жингдунг) нь Fortune 500 компанийн 52-д жагсдаг Хятадын хамгийн том онлайн худалдаа, тээвэр, үл хөдлөх хөрөнгө, инновац судалгааны компани юм. Стора.мн платформтой албан ёсны гэрээг байгуулснаар JD.com дээр байршиж буй хүнс бус өргөн хэрэглээний барааг Монголын хэрэглэгчид авах боломжтой боллоо.

Энэхүү хамтралын хүрээнд хоёр платформ хоорондоо холбогдож зогсохгүй, JingDong Logistic-той хамтран Хятадын өнцөг булан бүрээс Монгол Улс руу тээвэрлэх тээврийн гэрээг мөн байгуулсан. Энэ нь хэрэглэгчдэд илүү өргөн сонголт, хурдан, найдвартай хүргэлтийг санал болгож, худалдааны процессыг хөнгөвчлөхөд чухал алхам болж байна.





StoreForGood – Байгалд хайртай сонголт

Стора Централ ХХК нь Тогтвортой хөгжлийн 17 зорилгын хүрээнд StoreForGood нэртэй төслийг санаачлан хэрэгжүүлж эхлэв. Уг төсөл нь хүмүүсийн дутуу хэрэглэн хаядаг, хэрэгцээгүй худалдан авалтыг бууруулж, үйлдвэрлэх нөөц болон байгальд шингэх хор хөнөөл ихтэй бүтээгдэхүүнийг хоорондоо солилцон хэрэглэх замаар эдлэхүүнийг уртасгаж, хог хаягдлыг багасгах зорилготой.

Энэхүү төслөөр дамжуулан, стора.мн болон сторабоксн дэд бүтцийг ашиглан хүмүүс хоорондоо:

1. Ном
2. Хүүхдийн тоглоом
3. Хувцас

солилцох боломжийг бүрдүүлж байна. Цаашид солилцох бүтээгдэхүүний хүрээг нэмэгдүүлж, байгальд ээлтэй сонголтыг хийж, өөрийн хэрэглэхээ больсон эд зүйлсээ хоорондоо солилцох шинэ үеийн трендийг бий болгон хөгжүүлэхээр төлөвлөж байна.




Байгууллагын хангамжийн аутсорсинг үйлчилгээ

Албан байгууллагуудад тулгамддаг төрөл бүрийн худалдан авалт, үнэ харьцуулалт, судалгааны ажлыг хөнгөвчлөх зорилгоор бизнесийн харилцагчдад зориулсан цогц худалдан авалтын үйлчилгээний шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд танилцууллаа.

Энэхүү үйлчилгээний хүрээнд албан байгууллагууд Америк болон Хятадаас хүссэн тоног төхөөрөмж, мерч бүтээгдэхүүн, тусгай хэрэгцээт бараа, оффис тавилга, электрон бараа, бичиг хэргийн бүтээгдэхүүн, бэлэн дурсгалын зүйлс гээд бүх төрлийн бүтээгдэхүүнийг илүү хямд, өргөн сонголттойгоор захиалах боломжтой.

Энэхүү үйлчилгээ нь захиалга, тээвэрлэлт, гаалийн бүрдүүлэлт, судалгаа, зөвлөгөө, үнийн харьцуулалт зэрэг цогц шийдлүүдийг багтааж, албан байгууллагуудын худалдан авалтын процессыг хялбарчилж, илүү үр дүнтэй болгоход тусалж байна.





ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Тогтвортой хөгжлийн, бодлого, стратеги	1
Байгаль орчин	1
Нийгэм	1
Засаглал	1



Тогтвортой хөгжлийн, бодлого, стратеги

Хэдийгээр Премиум Нэксус ХК-д тогтвортой хөгжлийн бодлого, зорилтуудыг тодорхойлсон, хэрэгжилтийг хангасан журмын зохицуулалт хийсэн тухайлсан баримт бичиггүй боловч байгууллагын удирдлагын зүгээс тогтвортой хөгжлийн чиглэлд өгч буй анхаарал зэргийг үндэслэн байгууллагын цаашдын бодлого, стратегид тогтвортой хөгжлийн асуудлуудыг үндсэн асуудлуудын нэгээр тодорхойлж, холбогдох бодлогын баримт бичгийг боловсруулж, удирдлагын түвшинд манлайлал үзүүлэн ажиллаж, компанийн Ёсзүйндүрмийг шинэчлэн Шүгэлүлээх үйл ажиллагааны журам, Гомдол хүлээж авах, барагдуулах журмыг боловсруулан, хэрэгжүүлж байна. Үйл ажиллагааны зорилго, зорилтоо Тогтвортой хөгжлийн 17 зорилготой уялдуулан тодорхойлон төлөвлөж, хэрэгжилтийг ханган үр дүнг бүх оролцогч талуудад нээлттэй, ил тодоор тайлагнах үйл явц төлөвшин жигдэрсэн байна.

УДИРДЛАГА, БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Премиум Нэксус ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 2-р сарын 25-ны өдрийн 7 тоот тогтоолоор (“ТУЗ”)-ийн дэргэдэх Байгаль орчин, нийгэм, засаглалын хороо (“БОНЗ-ын хороо”)-ны үйл ажиллагааны журмыг баталсан бөгөөд БОНЗ-ын хорооны үйл ажиллагааны чиглэл, эрх үүргийн дагуу 3 сар тутам хуралдаж, БОНЗ-ын чиглэлд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаар ТУЗ-д жилд хоёроос доошгүй удаа тайлагнах үүрэг хүлээдэг.

БОНЗ-ын Хороо нь гурваас дээш гишүүнтэй байх ба гишүүдийн гуравны хоёр нь заавал хараат бус гишүүн байна. Хорооны гишүүд болон Хорооны даргыг ТУЗ-ийн олонхын саналаар сонгох ба зөвхөн ТУЗ-ийн гишүүн Хорооны гишүүнээр сонгогдох эрхтэй байна. Хараат бус гишүүн хороог удирддаг.

ЧАДАВХ БЭХЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тогтвортой хөгжлийн сургалтын нэгдсэн хөтөлбөр гараагүй боловч Хөдөлмөрийн харилцаа, ХАБЭА, байгаль орчин, бэлтгэн нийлүүлэлтийн тогтвортой байдал чиглэлээр сэдэвчилсэн сургалтууд хийгдсэн. Мэдээллүүд нь холбогдох хэсэгт орсон болно.

ХЯНАЛТ

ТУЗ-ийн дэргэдэх “БОНЗ-ын хороо” нь компанийн БОНЗ-тай холбоотой бодлого, стратеги болон дүрэм журмыг боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих, дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг хянан нягтлах үүрэгтэй ажилладаг тул Аудитын хорооны чиг үүрэгт тогтвортой байдлын асуудал хамаардаггүй.

ТАЙЛАГНАЛ БА БАТАЛГААЖУУЛАЛТ

Премиум Нэксус ХК нь 2021 оноос эхлэн (олон нийтэд нээлттэй хувьцаат компани болохоосоо өмнө) БОНЗ-ын тайланг боловсруулж, хөндлөнгийн байгууллагаар баталгаажуулж, олон нийтэд нээлттэй байршуулж байна. 2022 оны тайлантай энд дарж танилцана уу.

ГИШҮҮНЧЛЭЛ, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран ажилладаг. НҮБ-н Бизнес ба Хүний Эрхийн чиглэлээр баримтлах зарчмыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхэд төр болон олон улсын байгууллагаас хөхиүлэн дэмжиж буйд хамтын чармайлтаар ТХ-н зорилго, зорилтуудыг биелүүлэхэд идэвхтэй оролцож байна.



БОНЗ-Н МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Премиум Нэксус ХК нь 2023 оны Байгаль орчин, нийгэм, засаглалын (БОНЗ) тайлангийн хүрээнд дотоод болон гадаад оролцогч талуудын саналд үндэслэн, байгууллагын үйл ажиллагаанаас үүдэлтэй БОНЗ-ын нөлөөллийн 14 хүчин зүйлээр материаллаг байдлын чанарын үнэлгээг хийсэн. Энэхүү үнэлгээ нь компанийн хувьд БОНЗ-ын аливаа асуудал оролцогч талууд болон байгууллагын хувьд хэр зэрэг чухал болохыг тодорхойлох, тухайн асуудал компанийн санхүүгийн гүйцэтгэл, нэр хүнд, урт хугацааны үнэ цэнийг бий болгох чадварт үзүүлэх боломжит нөлөөллийг үнэлэхэд чиглэсэн юм. 2024 оны БОНЗ-ын тайлангийн хувьд дээрх материаллаг байдлын үнэлгээг хадгалж, өмнөх онтой ижил 14 хүчин зүйлд үндэслэн үнэлгээ хийж, оролцогч талуудын чухалчилж буй асуудлуудыг үргэлжлүүлэн хянаж, тайлагнасан болно.

БОНЗ-ын нөлөөллийн хүрээнд авч үзсэн 14 хүчин зүйлсийн хүрээнд Премиум Нэксус ХК-ийн дэвшүүлсэн зорилтууд болон материаллаг байдлын үнэлгээний матриксыг харуулав.





Байгаль орчин

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Премиум Нэксус ХК нь Монгол Улсын "Байгаль орчныг хамгаалах тухай хууль", "Байгаль орчны үнэлгээний тухай хууль" болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэн, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг жил бүр эрх бүхий байгууллагаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажилладаг.

Мөн үйл ажиллагаанаасаа байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллийг бууруулах, байгаль орчныг хамгаалах чиглэлээр бодитой арга хэмжээ авч, тогтвортой хөгжлийн зарчмыг мөрдөн ажиллаж байна. Үүний хүрээнд 2024 онд группийн харьяа охин компаниуд нь Байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлтэд тусгагдсан зөвлөмжийн дагуу байгаль хамгаалах, орчны бохирдлыг бууруулах дараах арга хэмжээнүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна.

УДИРДЛАГА, БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Премиум Нэксус ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 2-р сарын 25-ны өдрийн 7 тоот тогтоолоор ("ТУЗ")-ийн дэргэдэх Байгаль орчин, нийгэм, засаглалын хороо ("БОНЗ-ын хороо")-ны үйл ажиллагааны журмыг баталсан бөгөөд БОНЗ-ын хорооны үйл ажиллагааны чиглэл, эрх үүргийн дагуу 3 сар тутам хуралдаж, БОНЗ-ын чиглэлд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаар ТУЗ-д жилд хоёроос доошгүй удаа тайлагнах үүрэг хүлээдэг.

БОНЗ-ын Хороо нь гурваас дээш гишүүнтэй байх ба гишүүдийн гуравны хоёр нь заавал хараат бус гишүүн байна. Хорооны гишүүд болон Хорооны даргыг ТУЗ-ийн олонхын саналаар сонгох ба зөвхөн ТУЗ-ийн гишүүн Хорооны гишүүнээр сонгогдох эрхтэй байна. Хараат бус гишүүн хороог удирддаг.

ТУЗ-ийн хорооны нэр	Гишүүдийн нэр	Албан түшаал
Байгаль орчин, нийгэм засаглалын хороо	Ө. Эрдэнэчимэг	Хорооны дарга, ТУЗ-ийн хараат бус гишүүн
	Гари Биондо	ТУЗ-ийн дарга (хараат бус)
	Ч. Мөнхчимэг	ТУЗ-ийн гишүүн




Эрчим хүч

Премииум Нэксус ХК нь өөрийн хоол үйлдвэрлэлийн төв, нэгдсэн агуулах, шар айраг болон кофе үйлдвэрлэл, түгээлтийн төв, тэдгээрийн оффисоос гадна хот хөдөөгийн 445 конвинеенс салбар дэлгүүр гэсэн объектуудад үйл ажиллагаа явуулдаг бөгөөд объектууд бүгд Цахилгаан Түгээх Сүлжээ ТӨХК-тэй Цахилгаан эрчим хүчээр хангах тухай гэрээ хийн 6,182,436,760 төгрөгийн төлбөрийг цаг хугацаанд нь төлсөн байна.

Тайлант жилд үйл ажиллагаандаа 23,594,880 кВт.ц-ийн эрчим хүч хэрэглэсэн бөгөөд үүнээс 20,269,967 кВт.ц нь цахилгаан, 3,325,812 кВт.ц нь дулаан байна. Өмнөх жилтэй харьцуулахад 2024 оны цахилгааны хэрэглээ 28.9%-иар нэмэгдсэн нь дэлгүүрийн тоо өмнөх оноос 81-р нэмэгдсэн мөн бусад охин компаниудын үйл ажиллагааны цахилгааны хэрэглээ нэмэгдсэнтэй холбоотой. Нийт цахилгааны хэрэглээний /Зураг 1/. 90 гаруй хувийг сүлжээ дэлгүүрүүдийн эрчим хүч болон дулааны хэрэглээ эзэлж байна. Салбар дэлгүүрүүдийн ашиглаж буй эрчим хүчний хэрэглээг борлуулалтын орлоготой харьцуулахад борлуулалтын орлого нэмэгдэхийн хирээр эрчим хүчний хэрэглээ ихсэж байна.


Эрчим хүчний хэрэглээ (компаниар)



Эрчимшил

Нийт эрчим хүчний хэрэглээний дийлэнх хувийг эзэлж байгаа салбар дэлгүүрүүд цахилгаан болон дулааны хэрэглээг нийт үйлчлүүлсэн хэрэглэгчийн тоотой харьцуулахад 1 хэрэглэгчид үйлчлэхэд 3.26 кВт.ц зарцуулдаг бол 1 сая төгрөгийн борлуулалт тутамд 27.87 кВт.ц эрчим хүч зарцуулдаг байна. Энэхүү эрчимшлийг анхны суурь жил болох 2019 онтой харьцуулахад 1 хэрэглэгчид үйлчлэхэд ашигладаг байсан эрчим хүчний хэмжээ 5.3 дахин ихэссэн хэдий ч 1 сая төгрөгийн борлуулалт хийхэд зарцуулдаг эрчим хүчний хэрэглээ 2.9 дахин буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь компанийн борлуулалтын орлого тутам дахь эрчим хүчний хэрэглээний үр ашиг нэмэгдэж байгаа, мөн нэг хэрэглэгч нэг бүтээгдэхүүн биш олон төрлийн бүтээгдэхүүн худалдан авдаг болохыг харуулж байна.

Эрчим хүчний эрчимшил





ТЭЭВЭР ЗОХИЦУУЛАЛТ

2024 онд хүргэлтийн үйлчилгээг өглөөний 04:00-08:00 цагийн хооронд тээвэрлэх үйл ажиллагааг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна. Хотын зүүн хэсэгт байрлах хүйтэн хэлхээний түгээлтийн төвөөр дамжуулан хөргүүр бүхий машинаар өдөр бүр 80,000-100,000 хүнсний бүтээгдэхүүнийг, баруун өмнөд хэсэгт байрлах ердийн түгээлтийн төвөөс энгийн ачааны машинаар өдөр тутмын хүнсний бүтээгдэхүүнийг салбар дэлгүүрүүдэд хүргэж байна.

Энэхүү хүргэлтийн хөдөлгөөний зохицуулалтын үр дүнд тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөний тоог эрс багасгаж, түгээлтийн цагаа түгжрэлгүй үеэр зохион байгуулснаар тээвэрлэлтийн хугацааг 4 дахин богиносгож, шатахуун зарцуулалтыг 80%-иар бууруулан, агаарын бохирдол болон хүлэмжийн хийн ялгарлыг мэдэгдэхүйц багасган ажиллаж байна.

Шатахуун зарцуулалт

- 80% 

Тээвэрлэлтийн хугацаа

4X богино



Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах арга хэмжээ

Сүлжээ дэлгүүрийн үйл ажиллагаанд CU апп ашигласнаар цаасны хэрэглээг бууруулсан бөгөөд энэ нь байгалийн нөөцийг хэмнэх, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад чиглэгдсэн ажлуудын нэг юм.

Нийт хүлэмжийн хийн эрчимшлийг тооцож үзвэл 1 хэрэглэгчид үйлчлэхэд 1.62 кгCO_{2e}, 1,000,000 төгрөгийн борлуулалт бүрд 45.15 кг CO_{2e} ялгаруулж байна.



Хог, хаягдлын судалгаа 2024

Хог хаягдлыг тээвэрлэдэг байгууллагууд нь хог хаягдлыг тогтоосон өдөр, хуваарийн дагуу ачилт, цуглуулалт хийдэггүйгээс шалтгаалан сүлжээ дэлгүүрүүдэд хог ихээр хуримтлагддаг. Үүнийг шийдэхийн тулд Салбар дэлгүүр, хоол үйлдвэрлэл болон түгээлтийн төвүүдэд хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах боломжийг судлахаар энэхүү судалгааг хийсэн.

Нэг үйлчлүүлэгч

30 ГР / өдөр

368 дэлгүүр

1625.7 ТН / жил

4454 КГ / өдөр

Нэг дэлгүүрээс өдөрт үүсэх хогны хэмжээ дунджаар **13 кг**

Нийт хог, хаягдлын 56 хувийг дараах байдлаар дахин боловсруулах боломжтой. Үүнээс:

Дахин боловсруулах

17%

Хүнсний хог хаягдлыг компост бордоо байдлаар ашиглах

39%

Картон цаас /кг/

26%

Хүнсний хаягдал /кг/

17%

Сав баглаа боодол хаягдал

8%

Ус ундааны хуванцар сав /кг/

6%

Гялгар уут /кг/

4%

Шилэн лонх /кг/

2%

Аюултай хог /кг/

2%

Метал сав, лааз /кг/

1%

Бусад хаягдал

33%



Хог, хаягдлын судалгаа 2024

Түгээлтийн төв

754.1 ТОНН / жил

Түгээлтийн төвийн хог хаягдлын 88 орчим хувийг дахин боловсруулах боломжтой байна.




Хог, хаягдлын судалгаа 2024

Хоолны үйлдвэр

190.5 ТОНН / жил

Хоолны үйлдвэрийн нийт хог хаягдлын 80 орчим хувийг дахин боловсруулах боломжтой байна.






Хог, хаягдлын судалгаа 2024

Хог хаягдлын судалгааны үр дүнгээс харахад Эх үүсвэр дээр ангилан ялгаж, дахин боловсруулалтыг хийснээр 2029 он гэхэд хог хаягдлаас үүсэх хүлэмжийн хийн ялгарлыг 2 дахин бууруулах боломжтой байна. Хог хаягдлыг ангилан ялгаж, дахин боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлэх ажлыг 2025 оноос шатлалтайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Нүүрс хүчлийн хийн ялгарал

1 метр тонн CO₂

- Нийт
- Бууралт (компост үйлдвэрлэл)
- Бууралтын зөрүү




2024 он	2025 он	2026 он	2027 он	2028 он	2029 он	2030 он
1491	2062.2	2371.3	2741.4	3080.5	3420.6	3759.8
1490	2041.4	2078.1	2246.7	2585.3	2870	3085
0	20.8	293.2	494.7	495.2	550.6	674.8

Метан хийний ялгарал

1 метр тонн CH₄

- Нийт
- Бууралт (компост үйлдвэрлэл)
- Бууралт зөрүү



2024 он	2025 он	2026 он	2027 он	2028 он	2029 он
21	29.2	34	38.8	43.5	48.3
21	28.9	22.2	22.2	25.5	28.3
0	0.3	11.8	16.6	18	20

Нийгэм

2024 оны байдлаар Премиум Нэксус ХК нь нийт 4342 ажилтантай, үүнээс 4013 нь Улаанбаатар хотод, 329 нь орон нутгийн 13 аймагт ажиллаж байна. Компани орон нутгийн үйл ажиллагаагаа идэвхтэй тэлж байгаа бөгөөд орон нутгийн ажилтны тоо тогтмол өсөж байна.

Орон нутгийн нутгийн ажиллах хүчийг нэмэгдүүлэх бодлого нь бодлого нь дараах зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ. Үүнд:

- Орон нутгийн иргэдийг тогтвортой орлоготой, ажлын байртай болгох. Шилжилт хөдөлгөөнийг бууруулж, гэр бүлтэйгээ хамт байх нөхцөлийг бүрдүүлэх.
- Орон нутгийн залуусын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, чадварлаг хүний нөөцийг бүс нутагт үлдээх.
- Хөдөлмөрийн зах зээлийн төвлөрлийг сааруулах.

Эдгээр зорилтууд нь нийгэм, эдийн засгийн хүртээмжтэй хөгжлийг дэмжих чухал алхам болж байна.

Цаашид Премиум Нэксус ХК нь орон нутгийн ажиллах хүчний бүтцийг улам өргөжүүлж, эдийн засгийн урт хугацааны эерэг нөлөө үзүүлж, хөгжлийг дэмжих стратегитай ажиллахаар зорьж байна. Үүний хүрээнд шинээр нээгдэх салбар дэлгүүрүүдэд орон нутгийн иргэдийг сургаж хөгжүүлж, тогтмол ажлын байраар хангаж, тогтвортой орлогын эх үүсвэртэй болгох бодлогыг тууштай хэрэгжүүлнэ.

Бүс нутаг	Ажилтны тоо
Архангай аймаг	21
Булган аймаг	14
Говьсүмбэр аймаг	7
Дархан-Уул аймаг	28
Дорноговь аймаг	21
Дундговь аймаг	7
Орхон аймаг	56
Өвөрхангай аймаг	21
Өмнөговь аймаг	42
Сэлэнгэ аймаг	42
Төв аймаг	49
Хэнтий аймаг	21
Улаанбаатар хот	4013
Нийт	4342



Хүний нөөц ба олон талт тэгш байдал, хүртээмж

Премиум Нэксус ХК нь хүний нөөцийн бодлогодоо олон талт байдал, тэгш боломж, хүртээмжтэй хөдөлмөр эрхлэлтийн зарчмыг нэн тэргүүнд баримталдаг. Компанийн ажиллах хүчний бүтцийн хувьд бүх насныхныг хамарсан, нийгмийн бүхий л давхаргын иргэдийн төлөөллөөс бүрдсэн бүтэцтэйгээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж байна.

Залуусын хөдөлмөр эрхлэлтэд онцгой хувь эзлэх бөгөөд ур чадвартай ирээдүйн ажиллах хүчийг бэлтгэхийн тулд сургалт, хөгжлийн бодлогоор хангадаг. Мөн, ажлын анхны туршлагыг олгох чухал платформ болж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоо

Премиум Нэксус ХК нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажилд авах, ажиллуулах талаар нээлттэй бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлдэг. 2024 оны байдлаар нийт 129 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллаж, тэдний ажлын гүйцэтгэл болон оролцоог дэмжих онцгой арга хэмжээнүүдийг авч байна. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудад зориулан богиносгосон ажлын цагийн хуваарь санал болгож, ур чадвараа сайжруулах, карьер ахих боломжийг олгож, үнэ цэнтэй, урам зоригтой, өсөн дэвших боломжтой орчинд ажиллах нөхцөлийг хангахыг зорьдог.

Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудын нийгмийн идэвх, өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлж, бусад хамт олон, үйлчлүүлэгчдэд эерэгээр нөлөөлөхөд хувь нэмэр болж байна.

Олон талт тэгш байдал ба хүний нөөцийн үндсэн бодлогын тулгуур зарчмууд:

- Шударга, нээлттэй сонгон шалгаруулалт
- Тасралтгүй суралцаж, өсөж хөгжих нээлттэй байдал
- Олон талт тэгш байдал
- Сэтгэл ханамжтай ажилтан

Энэхүү бодлогын хүрээнд Премиум Нэксус ХК нь Хүртээмжтэй, Тэгш боломжийг хөдөлмөрийн зах зээлд бий болгохыг зорьж байна.

Ажиллах хүч /нас/	Ажилтны тоо	Эзлэх хувь
45-71 насны ажилтны тоо	159	4%
35-44 насны ажилтны тоо	384	9%
25-34 насны ажилтны тоо	807	18%
18-24 насны ажилтны тоо	2992	69%

Хүйсийн бүтэц, жендэрийн тэгш байдал

Үзүүлэлт	Эрэгтэй	Эмэгтэй
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд (9)	22%	78%
Гүйцэтгэх болон дунд шатны удирдлага	46%	54%
Нийт ажилтан	67%	33%

Премиум Нэксус ХК нь үйл ажиллагаандаа хүний эрх, хүний нэр төрийг дээдэлсэн, тэгш оролцоог хангах зарчмыг тууштай баримталдаг. Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд жендерийн тэгш байдлыг хангах зохицуулалт тусгагдсан бөгөөд компанийн бүх түвшинд ижил тэгш боломжийг олгох, хүйсийн болон бусад хэлбэрийн ялгаварлалгүй, шударга орчныг бүрдүүлэхийг зорьдог. Энэхүү зарчим нь байгууллагын хэмжээнд жендерийн тэгш оролцоог баталгаажуулж, ажилтан хоорондын харилцан хүндлэл, ойлголцолд суурилсан байгууллагын соёлыг төлөвшүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлдэг. Ийнхүү Премиум Нэксус ХК нь эерэг, хамтран ажиллах таатай нөхцөлийг бий болгож, байгууллагын соёлыг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг дэмжиж ирсэн.



Талент ба сургалт хөгжил

Премиум Нэксус ХК нь байгууллагынхаа үнэт зүйлсийг өдөр тутмын үйл ажиллагаандаа шингээж, ажилтнуудын итгэл, урам зориг, өөртөө итгэх мэдрэмжийг бүрэн дэмжсэн ажлын орчныг бүрдүүлэхийг зорьдог. Ийм соёлтой орчин нь манай байгууллагын хамгийн үнэт капитал болох ажилтнуудын чадварыг бүрэн нээж, хөгжүүлэх суурь нөхцөлийг хангадаг.

Бид зах зээлээс шилдэг ухаантнуудыг татахын зэрэгцээ дотоод ажиллах хүчээ сургаж хөгжүүлэхэд анхаарч, ажилтнуудаа ур чадвар, манлайллын чадавхтай, салбар дамнасан үнэ цэн бүхий мэргэжилтнээр төлөвшүүлэх зорилгоор сургалт, хөгжлийн бодлогыг хэрэгжүүлдэг.

Манай ажилтнууд үүрэгт ажлаа үр дүнтэй гүйцэтгэхийн зэрэгцээ салбарын шинэ түвшний ур чадварт чиглэсэн ажлын байран дээрх сургалтын хөтөлбөрүүдэд хамрагдах боломжтой. Ингэснээр ажилтнууд манай компанид зогсолтгүй өсөж, хөгжих боломжтой гэдэгт итгэж, байгууллагын амжилтад урт хугацааны хувь нэмэр оруулах сэтгэлтэйгээр ажиллаж байна.

Бид хүний нөөцөө зөвхөн одоогийн хэрэгцээнд бус, ирээдүйн хөгжилд чиглүүлэн бэлтгэж, нийгэмд эерэг нөлөө үзүүлэхүйц шилдэг багийг бүрдүүлэхэд анхаарч ажилладаг.

Ажилтан бүр өөрсдийн ур чадварын хэрэгцээ, шаардлагад нийцсэн сургалт, хөгжлийн системийг бүрдүүлж, түүнд тохирсон сургалтын хөтөлбөрүүдийг эзэмших боломжтой. Ингэхдээ ажилтан бүр өөрийн эзэмших шаардлагатай ур чадвараа үнэлж, удирдлага болон компанийн зүгээс дэмжлэг авч, ур чадварын зөрүүг нөхөх хөгжлийн төлөвлөгөө гаргаж ажилладаг.

Үзүүлэлт	Тоо хэмжээ
Сургалтын төрөл	16 төрөл
Сургалтын нийт хүн цаг	31,999 хүн*цаг
Хамрагдсан ажилтны тоо (давхардсан)	11,672
Карьер ахисан ажилтны тоо	811
Карьер ахисан ажилтнуудын эзлэх хувь	19%



Сургалт хөгжлийн бодлого

Сургалт хөгжлийн бодлого нь компанийн бизнес стратегитай уялдахаас гадна, ажилтан бүрийн карьерын зорилгодоо хүрэхэд нь дэмжлэг үзүүлэх хүн төвтэй зарчмыг баримталдаг. Премиум Нэксус ХК нь 2023 онд сургалтын цогц системээ шинэчилж, ажилтнуудын карьерын өсөлтөд бодитой нөлөө үзүүлэх хэд хэдэн хөтөлбөрийг хэрэгжүүлсэн.

Энэхүү хөтөлбөрийн нэг нь "цалинтай сургалт" бөгөөд компанийн зохион байгуулж буй бүх сургалтад ажилтнууд ажлын цагаар цалинтайгаар хамрагдах боломжтой болгосон. Мөн оффисын ажилтнуудын хувьд мэдлэгээ нэмэгдүүлэх, өөрийгөө хөгжүүлэх зорилгоор Баасан гараг бүрийн 9-11 цагийг "сургалт хөгжлийн цаг" болгон зарласан нь ажилтны өөрөө суралцах соёлыг төлөвшүүлэх чухал алхам болсон.

2024 оны байдлаар компани нь ажилтнуудыг ажлын байранд чиглүүлэх, дасан зохицуулах, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, мэдлэг олгох зорилгоор менежментийн нийт 16 төрлийн 31,999 хүн цагийн сургалтыг зохион байгуулсан бөгөөд давхардсан тоогоор нийт 11,672 ажилтныг хамруулсан. Энэ нь ажилтнуудын чадавхжуулах, мэргэшил дээшлүүлэхэд зохих дэмжлэг үзүүлж байна.

Түүнчлэн "Премиум Нэксус" ХК-ийн дэргэдэх сургалтын төв нь 2024 онд Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Сургалт, Үнэлгээ Судалгааны Институтийн баталгаажилтын дагуу "Худалдааны газрын үндсэн ажилтан" мэргэшлээр мэргэжилтэн бэлтгэх тусгай зөвшөөрөл авсан. Энэ нь дэлгүүр дээр ажиллаж буй бүх ажилтнуудад мэргэжлийн ур чадвар эзэмших, ажлын орчинд таатай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх боломжийг олгож байна.

Ялангуяа сургалтын төвд суралцсанаар Монгол улсын Боловсролын яамнаас хүлээн зөвшөөрөгдсөн "Худалдааны газрын үндсэн ажилтан" мэргэшилтэй болж төгсөх боломжтой болсноор хөдөлмөр эрхлэх, тасралтгүй суралцах боломж үүсэж байна.

Карьерыг дэмжих хөтөлбөрүүд

Премиум Нэксус ХК нь хүний нөөцийн тогтвортой өсөлт, хөгжлийг бий болгохын тулд шударга, ил тод үнэлгээний системээр дамжуулан ажилтнуудын карьер хөгжлийг дэмжин ажиллаж байна.

Карьер зэрэглэлийн үнэлгээ:

Ажилтнуудын ажлын үр дүн, мэргэжлийн ур чадварыг шударга, ил тод үнэлж, үнэлгээнд тэнцсэн ажилтнуудын карьерын шатлалыг ахиулдаг. 2024 онд нийт 3,385 ажилтан мэргэжлийн ур чадвараа үнэлүүлэх карьер зэрэглэлийн үнэлгээнд оролцсоноос 811 ажилтан үнэлгээндээ тэнцэж, карьер зэрэглэлээ ахиулсан байна.


Тэгш боломж, олон талт байдлыг дэмжих:

Байгууллагын орчинд ялгаварлалгүй, эрх тэгш соёлыг төлөвшүүлэхийг зорьж, жендерийн тэнцвэр, олон талт байдал, өөр өөр авьяас, чадварыг бүрэн дэмждэг. 2024 онд нийт ажилтны 70% нь эмэгтэй байсан бөгөөд энэ онд нийт карьер зэрэглэлээ ахиулсан ажилтнуудын 77% нь эмэгтэй ажилтнууд байв.

Ийнхүү, талант менежментийн бодлогоор дамжуулан байгууллага нь ажилтнуудынхаа ур чадварыг үнэлэх, карьерын ахиц, тэгш боломжийг хангах тогтвортой орчныг бүрдүүлж, ажиллах хүчний үнэ цэнийг нэмэгдүүлж байна

Сургалтууд

- Менежерийн чиглүүлэх сургалт
- Менежер коллеж
- Ажилтнуудын чиглүүлэх сургалт
- Менежер ОJT
- Ажилтнуудын албан журмын сургалт
- Франчайзын үйл ажиллагаа
- SC коллеж
- SC чиглүүлэх сургалт
- Хүний нөөц
- Санхүү
- Бусад
- Эрсдэл
- Маркетинг
- Тогтвортой хөгжил
- SC OJT





Сургалт хөгжлийг дэмжигч шилдэг ажил олгогч

Хөдөлмөрийн зах зээлийн хамгийн том чуулган болох “MONGOLIAN LABOR MARKET SUMMIT: Good Workplace Awards 2024” нь хүний нөөцийн салбарын хүндэтгэлтэй байгууллагуудыг шалгаруулдаг нэр хүндтэй арга хэмжээ юм. Энэ удаагийн шалгаруулалтад 270 гаруй компанийн материалыг 10 номинацийн хүрээнд хүлээн авсан бөгөөд олон талт шүүгчдийн бүрэлдэхүүнтэй онооны системээр үнэлжээ.

Шалгаруулалтын үр дүнд 2024 оны “Best Training (Upskilling)” буюу “Сургалт Хөгжлийг Дэмжигч Шилдэг Ажил Олгогч” номинацийн эзнээр “Премиум Нэксус” ХК тодорсон.

Энэхүү амжилт нь тус байгууллага ажилтнуудынхаа тогтвортой хөгжил, ур чадварын ахиц, олон улсын хөдөлмөрийн стандартыг мөрдөх зэрэг хувь нэмрийг өндрөөр үнэлснийг илтгэж байна.

Энэхүү шагнал нь Премиум Нэксус ХК-ийн хүний нөөцийн бодлогын үр дүнг илтгэж, байгууллагын өсөлт, хөгжлийг дэмжихэд чиглэсэн оролцоог үнэлэх чухал алхам болсон юм.

Премиум Нэксус ХК нь ажилтнуудын сэтгэл ханамж, оролцооны түвшнийг тогтмол үнэлж, байгууллагын соёлыг тасралтгүй сайжруулах замаар ажиллах хүчний тогтвортой байдлыг хангахад анхаарал хандуулдаг. Энэ хүрээнд 2024 онд Gallup-ийн аргачлалд үндэслэн ажилтны сэтгэл ханамжийн судалгааг зохион байгуулсан бөгөөд нийт үндсэн ажилтнуудын 85% нь уг үнэлгээнд хамрагдсан.

Судалгаа нь төв оффис, агуулах, түгээлтийн төв, үйлдвэр, салбар дэлгүүр зэрэг бүх үйл ажиллагааг хамарсан өргөн хүрээг хамран явуулдаг. Судалгаагаар нийт ажилтнуудын сэтгэл ханамжийн түвшин 73%-тай хэмээн үнэлэгдсэн бөгөөд энэ нь 2023 оны үзүүлэлтээс 1%-аар нэмэгдсэн үзүүлэлт юм.

Судалгаанд хамрагдсан ажилтнуудаас 68% нь компанийн ажлын орчныг найз нөхөд, гэр бүлийн хүрээлэлдээ санал болгоход бэлэн гэж хариулсан бол 62% нь ирэх хоёр жилд компанидаа үргэлжлүүлэн ажиллах төлөвлөгөөтэй байгаагаа илэрхийлсэн байна. Мөн карьер дэвших, ажлын үнэлгээ, тушаал ахих бодлогод шударга гэсэн үнэлгээ нэмэгдэж байгаа нь ажилтны итгэл, урам зоригтой холбоотойгоор илэрч байна.

Энэхүү судалгаа нь Премиум Нэксус ХК-ийн хүний нөөцийн бодлого, ажилтнуудын талаарх хүндэтгэлийг илтгэдэг бөгөөд байгууллагыг цаашид хэрхэн хөгжүүлэхийг тодорхойлоход чухал ач холбогдолтой.



Премиум Нэксус" ХК нь "Ажилтан бүр өглөө ажилдаа эрүүл саруул ирээд, буцаад харихдаа эрүүл саруул гэртээ харих, хэрэглэгч аюулгүй орчноор үйлчлүүлэх" гэсэн зорилго тавьж ажилладаг. Энэхүү зорилгодоо хүрэхийн тулд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн (ХАБЭА) менежментийн тогтолцоог нэвтрүүлэн, хэрэгжүүлж ажиллаж байна. Компанийн ХАБЭА менежментийн тогтолцоог PDCA (Төлөвлөх- Хэрэгжүүлэх-Хянах-Сайжруулах) загварын дагуу хэрэгжүүлдэг.

"Премиум Нэксус" ХК нь 2020 оны 06 дугаар сарын 03-ны өдөр Гүйцэтгэх захирлын А/20-ны 29 тушаалаар анх ХАБЭА-н бодлогыг баталсан бөгөөд одоо нийт 14 журамтай.

ХАБЭА-н журам:

- ХАБЭА-н ерөнхий журам
- Ээлж хүлээлцэх, ажил эхлэхийн өмнөх хурлын журам
- Ажил зогсоох эрхийг хэрэгжүүлэх журам
- Осол зөрчлийн удирдлага журам
- Согтууруулах ундаа, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийн талаар баримтлах бодлого
- Эрсдэлийн удирдлагын журам
- Түгжих, пайзлах, энергийн эх үүсвэрт тусгаарлалт хийх журам
- Хязгаарлагдмал орчинд нэвтрэх, ажилбар гүйцэтгэх журам
- Өндөрт ажил гүйцэтгэх журам
- Өндөр хэмийн ажил гүйцэтгэх журам
- Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчны сургалт зохион байгуулах, мэдлэг бататгах сорил авах журам
- Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын зөвлөлийн журам
- Ажиллагсдын эрүүл мэндийн хяналтын журам
- Галын аюулгүй байдлын журам

Премиум Нэксус ХК-ийн ХАБЭА алба нь ХАБЭА менежментийн тогтолцооны хэрэгжилт, сайжруулалтыг хариуцаж, компанийн удирдлага ажилчдад мэргэжлийн дэмжлэг үзүүлж ажилладаг. ХАБЭА алба нь Гүйцэтгэх захирлын удирдлагад шууд харьяалагддаг бөгөөд 2 менежер, 3 мэргэжилтэн, 1 эмч гэсэн бүрэлдэхүүнтэй.

Компанийн дотор төдийгүй гэрээт болон туслан гүйцэтгэгч нарт ХАБЭА-н соёлыг бүрдүүлэх, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчлөлөөс сэргийлэх зорилгоор, шаардлагыг тодорхойлж, хэрэгжүүлэх гэрээнд тусган хэрэгжилтийн байдлыг гэрээнд тусгасан үзүүлэлтээр дүгнэдэг.

Энэхүү менежментийн тогтолцоо нь ажилтнуудын аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартын дагуу ажиллах чадварыг дээшлүүлж, компанийн хүчин чадлыг сайжруулахад чухал үүрэгтэй.



Ажилтны аюулгүй байдал

Компанийн зүгээс ажилтны аюулгүй байдлыг хангахад чиглэсэн олон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Бүх дэлгүүрийг камераар тоногловсон: Аюулгүй байдлыг хангах зорилгоор дэлгүүр бүхэнд хяналтын камер суурилуулсан байна.
- Харуул хамгаалалтын компанитай гэрээ байгуулсан: Дэлгүүрт аюултай нөхцөл үүсэхэд хамгаалалт дуудахад зориулсан тусгай товч байгаа бөгөөд товч дарснаас хойш 10 минутын дотор хамгаалалтын баг ирдэг.
- ХАБЭА-н Bukhbat гар утасны аппликейшн: Ажилтнуудад журам, заавар танилцуулах, аюулыг мэдээлэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор энэ аппликейшнийг ашиглаж эхэлсэн.
- Гэнэтийн ослын даатгал: Бүх ажилтныг гэнэтийн ослын даатгалд хамруулсан. Ингэснээр ажлын байрандаа, эсвэл гэртээ харих, ажилдаа ирэх замдаа ямар нэг осолд орох, гэмт халдлагад өртсөн тохиолдолд нөхөн олговор авах боломжийг бүрдүүлж байна.

“Аюулгүй ажиллагааны соёлыг хамтдаа түгээе” уриатай арга хэмжээнүүд: 2024 онд хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын эерэг соёлыг төлөвшүүлэх зорилготойгоор сар бүр идэвхжүүлэлтийн арга хэмжээг зохион байгуулж, аюулгүй ажиллагааны манлайлагч, шилдэг ажилтнуудыг тодруулан эрхийн бичиг болон үнэ бүхий зүйлсээр шагнасан.

Гэнэтийн ослын даатгалаас гадна компанийн гуравдагч этгээд болон хамааралтай этгээдүүдийн бие эрхтний гэмтэл, эрүүл мэнд, амь насанд учруулах хохирол, мөн эд хөрөнгийн эвдрэл, хохирлыг хамаарсан ерөнхий хариуцлагын даатгалтай.

Гэрээт болон туслан гүйцэтгэгч нарт тавих ХАБЭА-н шаардлагад гэрээт компани нь өөрийн ажилтнуудаа гэнэтийн ослын даатгал, жолоочийн хариуцлагын даатгал, мэргэшсэн жолоочийн даатгал, машин болон тоног төхөөрөмжийн даатгалд хамрагдахыг шаарддаг.

Онцгой байдлын үеийн бэлэн байдал

Премиум Нэксус ХК нь барилга байгууламж, объект дээр гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ, гамшгаас хамгаалах төлөвлөгөөг онцгой байдлын асуудал эрхэлсэн харьяа байгууллагатай хамтран боловсруулсан. Компанийн гүйцэтгэх захирлын А/24-66 тоот тушаалаар гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийг томилсон.

Дэлгүүр бүр галын аюулгүй байдлыг хангах зорилгоор:

- 2 гал унтраагуур
- Галын хөнжил
- Угаарын хий мэдрэгч сенсорoor тоноглогдсон

Тоног төхөөрөмжийн хугацааг тогтмол хяналтын хуудас хөтөлж, аюулгүй байдлыг хариуцдаг.

Мөн хүнсний үйлдвэр нь 100% автомат гал хамгааллын системтэй. Газын байгууламж нь мэдрэгч сенсортой бөгөөд, газ алдагдсаны тохиолдолд автоматаар хэрэглээг зогсоох, унтрах тохиргоотой.

Энэхүү арга хэмжээ нь онцгой байдлын үед эрсдэлийг бууруулж, ажилтнуудын аюулгүй байдлыг хангах, үйл ажиллагаа явуулахад шаардлагатай бэлэн байдлыг бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна.

CU сүлжээ дэлгүүрийн хувьд хоолны бүтээгдэхүүн нийлүүлэгч нарын хөгжлийг дэмжих

2022 оноос CU сүлжээ дэлгүүр нь бэлтгэсэн хоол нийлүүлэгч нарын чадавхыг сайжруулах чиглэлээр хөтөлбөрийг санаачлан эхлүүлсэн. Хүнсний аюулгүй байдлыг хангах зорилгоор хамтран ажилладаг хоолны бүтээгдэхүүн нийлүүлэгч нартаа ажлын байрны угтвар нөхцөлийг сайжруулах, эрүүл ахуйн дадал хэвшлийг байнга мөрдөж хэвшүүлэх зорилгоор НАССР (НАССР) стандартыг хэрэгжүүлэх “Хамтдаа хөгжье” хөтөлбөрийг 4 үе шаттайгаар хэрэгжүүллээ.

2023 онд нийт 6 нийлүүлэгч НАССР стандартыг хэрэгжүүлсэн бөгөөд 2024 оны байдлаар нийт 11 үндэсний үйлдвэрүүд НАССР стандартын баталгаажилтад хамрагдаж сертификатаа авсан.

Эдгээр аж ахуйн нэгжүүд НАССР-ийн стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр түүхий эд бэлтгэн нийлүүлэлтээс эхлэн үйлдвэрлэх, түгээх, хадгалах, хэрэглэгчид хүргэх бүхий л үе шатанд бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг ханган нарийн хяналт шалгалтын дор эрүүл, баталгаатай хоол хүнс үйлдвэрлэх, хэрэглэгчдэд найдвартай аюулгүй бүтээгдэхүүнээр үйлчлэх боломжтой болж байна.

2025 ондоо CU сүлжээ дэлгүүр нь дахин 5 нийлүүлэгчийг НАССР стандарт хэрэгжүүлэн баталгаажуулалтад хамруулах зорилготой бэлтгэл ажилдаа орж, амжилтад хүрэхэд тогтвортой хүч үзэхээр төлөвлөж байна.

НАССР стандарт хэрэгжүүлсэн 11 үндэсний үйлдвэрлэгч
нартай CU сүлжээ дэлгүүр хамтран ажиллаж байна.

Хүнсний аюулгүй байдлын эрсдэлийг бууруулах арга хэмжээ

CU сүлжээнд аюулгүй бэлтгэсэн хоол нийлүүлэхэд хүнсний аюулгүй байдлыг хангах үүднээс хэрэглэгчийн гомдол бууруулах арга хэмжээ

2024 онд CU сүлжээ дэлгүүр нь хүнсний аюулгүй байдлын эрсдэлийг бууруулах зорилгоор бэлтгэсэн хоолны бүтээгдэхүүн нийлүүлэгчид, түгээлтийн машин, салбар дэлгүүрүүд зэрэг гол дамжин өнгөрдөг цэгүүд дээр хяналтаа сайжруулан ажиллаж байна.

Энэхүү арга хэмжээний үр дүнд 2023 онтой харьцуулахад ноцтой гомдол бууруулчлүүлэгчийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх гомдлыг 15%-иар бууруулсан үзүүлэлттэй байна.

Энэ нь CU сүлжээ дэлгүүрийн хүний аюулгүй байдлын менежментийн тогтолцооны үр ашиг болон хүнсний бүтээгдэхүүний чанарт анхаарал хандуулж, эрсдэлийг зохих хэмжээгээр бууруулахад томоохон хувь нэмэр оруулж буйг илтгэж байна.





Хот суурин газрыг сайжруулах үйл ажиллагаа

CU дэлгүүрээр үйлчлүүлж буй сая хүн дараах үйлчилгээг ямар нэг худалдан авалт хийх нөхцөлгүйгээр санал болгож, нийслэл болон салбар дэлгүүр байршиж буй орон нутгийн хоол үйлчилгээний соёл, стандартыг өөр түвшинд авчраад 4 жил болжээ.



Ариун цэврийн газар:

Нийслэлд олон нийтийн ариун цэврийн байгууламжийг дангаар шийдэж өгсөн нь нийслэлийн иргэдийг ая тохитой амьдрах, олон жилийн турш гаргалгаа олдоогүй асуудлын шийдлийг бий болгосон хэрэг юм.



Гадна талбайн цэвэрлэгээ:

CU дэлгүүрүүд гадаад орчны 50м талбайгаа тохижуулсан гэрэлтүүлэгтэй, халтиргаа гулгаанаас хамгаалж цэвэрлэсэн байх шаардлага тавьдаг.



24 цагийн камержуулалт:

1 сарын хугацаатай хадгалагддаг камерын бичлэг хийгддэг бөгөөд хүмүүс юмаа мартаж орхих, хулгай, гэмт хэрэгт өртөх гэх мэт тохиолдлуудад холбогдох байгууллагын зөвшөөрлөөр бичлэг шүүж нотолгоо болсон тохиолдлууд бий.



Үнэгүй Wi-Fi цэг:

Хотын төв гэлтгүй захын бүсүүдэд кофе шоптой адил үйлчилгээ үзүүлэх ач холбогдолтой юм.



Шуудангийн үйлчилгээ:

Stora хүргэлтийн цэгүүд тодорхой цэгүүдэд байрласан. Мөн төрийн үйлчилгээний киоск цэгүүдийг байрлуулахаар төрийн холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна.



Хүргэлтийн үйлчилгээ:

Ковид-19 цар тахлын үед хүргэлтийн үйлчилгээг хэрэгжүүлж байсан нь өндөрлөсөн бөгөөд цар тахлын үед ч мөн зогсолтгүй хэрэглэгчдэдээ ойр байх зарчмыг баримтлан хэрэглэгчид хамгийн ойрын салбараасаа хамгийн хурднаар хүргэлтийг авах боломжтой байснаараа онцлог.

Вэлүү сангийн хүүхдийн сайн сайхны төлөө хөтөлбөрийг дэмжив

Премиум Корпорэйшн болон Премиум Нэкус нь нийгмийн хариуцлагын хүрээнд Вэлүү сангаас санаачлан хэрэгжүүлж буй хүүхдийн сайн сайхны төлөөх төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд Улаанчулуутын хогийн цэг орчимд амьдардаг өрхийн хүүхдүүдийг 340 сая төгрөгийн хандиваар дэмжихээр болов.

ICU хөтөлбөр

Премиум Нэкус ХК нь хүүхэд багачуудыг аюул ослоос хамгаалах, төөрсөн хүүхдүүдийг эцэг эх, асран хамгаалагчид нь хүлээлгэн өгөх зорилготой ICU хөтөлбөрийг Нийслэлийн Цагдаагийн Удирдах Газартай хамтран 2021 оноос хэрэгжүүлж байна. Тус хөтөлбөр нь зөвхөн төөрсөн хүүхдүүдийг хамгаалаад зогсохгүй, гэр бүлийн хүчирхийллээс үүдсэн аюултай нөхцөл байдлын үед хүүхдүүдэд түр орогнох байр болж, аюул өнгөртөл хамгаалах орчныг бүрдүүлж өгдөг. Хөтөлбөр эхэлснээс хойш хугацаанд гэрээсээ төөрсөн 14 хүүхдийг эцэг, эх, асран хамгаалагчид нь аюулгүй хүлээлгэн өгсөн.



Олон нийт рүү чиглэсэн аян



“Үзүүлээд Өгье” аян

Насанд хүрээгүй хүүхдэд насны хязгаарлалттай бүтээгдэхүүн болох электрон болон утаат тамхи, согтууруулах ундаа худалдан авахаас урьдчилан сэргийлж иргэний бичиг баримтыг шалган худалдаалахад уриалсан “Үзүүлээд Өгье” аяныг хэрэгжүүлсэн.



Соёл танаас эхэлнэ

Цагдаагийн Ерөнхий Газар болон GS25-тай хамтран "Соёл танаас эхэлнэ" аяныг амжилттай хэрэгжүүлсэн. Энэхүү аян нь нийтийн соёл ёс суртахууныг дээшлүүлж, илүү эелдэг, бусадтай илүү хүндэтгэлтэй харилцдаг сайхан нийгмийг бүтээхэд олон нийтийг уриалсан бөгөөд давхардсан тоогоор 65,278,300 хүнд хүрсэн томоохон аяны нэг болсон бөгөөд 2024 оны шилдэг зар сурталчилгааны бүтээлээр шалгарч “Мөнгөн мод” цом авсан билээ.

Засаглал

Премиум Нэксус ХК (“Компани”)–ийн засаглалын бүтэц нь Монгол Улсын холбогдох хууль, дүрэм журамд нийцсэн, үндсэн үйл ажиллагааны чиглэл, бодлого, стратегийг тодорхойлох, нөөц, дотоод хяналт, эрсдэлийг зөв зохистой удирдах, гүйцэтгэх удирдлагыг удирдан чиглүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн байдаг.

Компани нь Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Компанийн засаглалын кодекс болон олон улсад танигдсан шилдэг туршлага, зарчмуудыг баримталж, үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байгаа бөгөөд сайн засаглал нь бизнесийн стратегийг хэрэгжүүлэх, хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, тэдгээрийн ашиг сонирхлыг хамгаалах, бизнесийн ёс зүй, ил тод, шударга байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг хэмээн үздэг.

Хувьцаа эзэмшигчид ба хувьцаа

Компани нь олон нийтэд нээлттэй хувьцаат компани болох албан ёсны зөвшөөрлөө 2021 оны 10-р сарын 13-ны өдөр Санхүүгийн зохицуулах хороо (“СЗХ”)–ноос авч 2021 оны 11-р сарын 03-ны өдөр Монголын хөрөнгийн бирж ХК (“МХБ”)–ийн III дугаар ангиллаар нийтэд санал болгон үнэт цаасны анхдагч арилжаагаа амжилттай дуусгаж, 2021 оны 11-р сарын 12-ны өдрөөс хоёрдогч зах зээлийн арилжаагаа нээснээр нээлттэй хувьцаат компани болсон бөгөөд МХБ–ийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 05-р сарын 05-ны өдрийн А/42 тоот тушаалаар Компанийн үнэт цаасыг ангилал ахиулан II дугаар ангилалд бүртгэсэн.

2024 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар МХБ, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт бүртгэгдсэн Компанийн нийт гаргасан энгийн хувьцааны тоо 1,114,252,034 , нийт хувьцаа эзэмшигчдийн тоо 9,974 байсан.

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

Хувьцаа эзэмшигчид	2024 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар	
	Эзэмшлийн хувьцааны тоо	Эзэмшлийн хувь
А.Ганхуяг	300,848,138	27.00%
А.Ганболд	207,204,006	18.60%
Премиум Групп ХХК	191,266,240	17.17%
БиЖиЭф Ритэйл Ко., Лтд.	92,600,479	8.31%
Ц.Баяржаргал	88,164,258	7.91%
Олон нийт	234,168,913	21.02%
Нийт	1,114,252,034	100.00%

Хувьцаа

Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар	2023 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар	2024 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар
Нийт гаргасан энгийн хувьцааны тоо	817,768,643	817,768,643	1,114,252,034
Нийт хувьцаа эзэмшигчдийн тоо	10,108	9,615	9,974



Төлөөлөн удирдах зөвлөл

ТУЗ нь хувьцаа эзэмшигч болон бусад оролцогч талуудад урт хугацааны үнэ цэнийг бий болгох зорилгоор хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхолд нийцүүлсэн үндсэн үйл ажиллагааны чиглэл, бодлого, стратегийг тодорхойлж, гүйцэтгэх удирдлагыг Компанийн зорилго, зорилт, бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд удирдан чиглүүлж, хяналт тавин ажилладаг. ТУЗ нь 9 гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд эдгээр гишүүдийн 6 нь ердийн, 3 нь хараат бус гишүүд юм.

ТУЗ нь ТУЗ-ийн гишүүн З.Уянга-г 2024 оны 11-р сарын 07-ны өдрөөр үүрэгт ажлаас чөлөөлж, түүний оронд Ч.Мөнхчимэгийг ТУЗ-ийн гишүүн, ТУЗ-ийн Байгаль орчин, нийгэм, засаглалын хороо (“БОНЗ-ын хороо”)–ны гишүүнээр түр томилсон.

Компани нь шинээр томилогдсон ТУЗ-ийн гишүүнд Компанийн үйл ажиллагаа, бизнес, бодлого, дүрэм журмыг танилцуулан, чиглүүлэх сургалтыг хийсэн бөгөөд ТУЗ болон түүний хороодын бүрэлдэхүүнд орсон өөрчлөлтийг СЗХ болон МХБ-д мэдэгдэж, МХБ-ийн цахим хуудсаар дамжуулан мэдээлж мэдээллийн ил тод байдлыг ханган ажилласан.

ТУЗ нь тогтвортой хөгжлийн зорилт болон Хүний эрхийн зарчмуудыг баримтлал болгон шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэй гишүүдийн оролцоог нэмэгдүүлэхийг зорин ажилладаг бөгөөд 2024 оны байдлаар ТУЗ-ийн бүрэлдэхүүний 22.2 хувь нь эмэгтэй гишүүн, нийт ажиллагсдын дундаас дээш удирдлагын [48] хувь, ханган нийлүүлэгчдийн нийт ажиллагсдын дундаас дээш удирдлагын [76] хувь нь эмэгтэй удирдагч нар байсан байна.

ТУЗ-ийн цалин урамшуулал

2024 оны санхүүгийн жилд ТУЗ-ийн хараат бус гишүүдэд сарын 3 сая төгрөгийн цалин урамшуулал олгосон байна. ТУЗ-ийн гишүүд болон Гүйцэтгэх удирдлагын Компанид эзэмшиж буй хувьцааны тооны мэдээллийг дараах хүснэгтэд харуулав.

ТУЗ-ийн гишүүдийн сургалт, хөгжил

Компани нь ТУЗ-ийн гишүүнийг шинээр томилогдох бүрд Компанийн санхүүгийн тайлагнал, бизнесийн онцлог болон үйл ажиллагаа, ТУЗ-ийн гишүүний эрх, үүрэг, хариуцлага зэрэг мэдээллийг агуулсан танилцах хөтөлбөрт хамруулдаг.

ТУЗ-ийн гишүүд 2024 оны 06-р сарын 17-ны өдөр Компанийн засаглалын үндэсний зөвлөл, Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимаас хамтран зохион байгуулсан Компанийн засаглалын сургалтад хамрагдсан бөгөөд тус сургалт нь компанийн засаглалын сүүлийн үеийн чиг хандлага, ТУЗ-ийн үйл ажиллагааг үр ашигтай болгох, компанийн засаглалын маргаан шийдвэрлэх арга замууд, комплайнсын бодлого, эрсдэлийн менежмент гэсэн үндсэн 4 сэдвийн хүрээнд явагдаж оролцогчдод гэрчилгээ олгосон. Мөн ТУЗ болон удирдах ажилтнуудад зориулан Harvard Business Publishing-аас гаргадаг менежмент, манлайллын цахим сургалтын платформ дах Харвардын менежмент ба менторын сургалтад хамрагдах эрхийг нээж өгсний дагуу гишүүд, удирдлага тус сургалтад хамрагдаж байгаа бөгөөд тус хөтөлбөр нь цаашид ч үргэлжлэх юм. 2025 онд ТУЗ-ийн гишүүдийг компанийн засаглал болон Харвардын менежмент ба менторын сургалтад үргэлжлүүлэн хамруулахаар төлөвлөөд байна.

ТУЗ-ийн гишүүний нэр	Эзэмшиж буй хувьцааны тоо		Нийт хувьцаанд эзлэх хувь	
	Шууд	Шууд бус	Шууд	Шууд бус
Гари Биондо (дарга, хараат бус)	–	–	–	–
А.Ганхуяг	300,848,138	72,298,639	27.00%	6.49%
А.Ганболд	207,204,006	55,046,424	18.60%	4.94%
Г.Бат-Эрдэнэ	22,572,047	6,063,140	2.03%	0.54%
Ч.Мөнхчимэг	–	–	–	–
Г.Чинзориг	6,842,227	–	0.01%	–
Б.Бат-Эрдэнэ	80,000	–	0.61%	–
Ө.Эрдэнэчимэг	–	–	–	–
В.Ганзориг	2,709	–	0.00%	–

ТУЗ-ийн гишүүд



Гари Стивен Биондо

ТУЗ-ийн дарга
Премиум Нэксус ХК

Гари Стивен Биондо (Gary Stephen Biondo) нь Премиум Нэксус ХК-ийн ТУЗ-ийн дарга (хараат бус) бөгөөд Улаанбаатар дах Олон Улсын Дунд Сургуулийн ТУЗ-ийн дарга, Монгол дах АНУ-ын худалдааны танхим (АмЧам Монгол)-ын ТУЗ-ийн дарга, Эдельвайс Арт зочид буудлын гүйцэтгэх захирал юм. Тэрээр 35 гаруй жил зочид буудлын менежментийн салбарт, тэр дундаа ажилчдын сургалтын хөтөлбөр, Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын стандарт, чанар, дотоод хяналтын удирдлага, галын аюул, осол үүсэх эрсдэлийн удирдлагын тогтолцоог амжилттай хэрэгжүүлж, хяналт тавьж ажилласан туршлагатай. Гари Биондо нь Азийн өөр өөр соёл иргэншилтэй олон улс орнуудад өндөр зэрэглэлийн Шангри-Ла олон улсын зочид буудал, резортод 28 жил ерөнхий менежер, гүйцэтгэх удирдлагаар ажилласан бөгөөд АНУ-ын Колорадо мужийн Колорадо Коллежийг сонгодог уран зохиол, гүн ухааны чиглэлээр бакалаврын зэрэгтэй төгссөн.



Адилбишийн Ганхуяг

ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал
Премиум Нэксус ХК

Адилбишийн Ганхуяг нь Премиум Корпорэйшний үүсгэн байгуулагч, Премиум Нэксус ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал бөгөөд сүүлийн 23 гаруй жил Монголын нэр нөлөө бүхий томоохон компаниуд болох М-Си-Эс Группийн Тэргүүн дэд ерөнхийлөгч, М-Си-Эс Холдинг ХХК-ийн Гүйцэтгэх захирал, М-Си-Эс Кока-Кола ХХК болон Юнител ХХК-ийн ТУЗ-ийн дарга, Монголиан Майнинг Корпорацийн (НКЕХ: 975)-ийн ТУЗ-ийн гишүүн, Санхүү эрхэлсэн дэд ерөнхийлөгч, Улаанбаатар Хотын Худалдааны Танхимын Ерөнхийлөгчөөр ажиллаж ирсэн туршлагатай. Тэрээр эдгээр компаниудын үйл ажиллагааг олон улсын түвшинд хүргэх, таниулахад үнэтэй хувь нэмэр оруулж, эрчим хүч, уул уурхай, хөнгөн үйлдвэр, дэд бүтэц, барилга, худалдааны салбарт томоохон хэмжээний гадаадын хөрөнгө оруулалт татах ажлыг амжилттай удирдан зохион байгуулсан. А.Ганхуяг нь Монгол Улсын Их Сургуулийг санхүү, эдийн засгийн бакалавр, Квантик Бизнес, Технологийн Сургуулийг бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй төгссөн.



Адилбишийн Ганболд

ТУЗ-ийн гишүүн
Премиум Нэксус ХК

Адилбишийн Ганболд нь Премиум Нэксус ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Премиум Корпорэйшний үүсгэн байгуулагч, Премиум Иннова ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн бөгөөд түүний зэргэлдээ, хараат компаниудын үйл ажиллагааг удирдан, стратегийн чиглэл, зорилтыг хэрэгжүүлэхэд тэргүүлэх үүрэг гүйцэтгэж ирсэн. Монгол Улсын авто зам барилга, хотын дэд бүтцийн компани болох Нэйшнл Девелопер ХХК-ийн Гүйцэтгэх захирал, тансаг зэрэглэлийн тавилга үйлдвэрлэгч Ганброс ХХК-ийн үүсгэн байгуулагч бөгөөд Ерөнхий захирлаар ажиллаж байсан. Түүний барилгын салбарын хөгжилд оруулж буй хувь нэмрийг төр засгаас өндрөөр үнэлж Алтан гадас одонгоор шагнасан юм. Тэрээр Оросын Холбооны Улсын Харьков хотын Барилгын дээд сургууль, Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль ("ШУТИС")-ийг цахилгаан тээвэр, системийн инженер мэргэжлээр суралцсан, бакалаврын зэрэгтэй.

ТУЗ-ийн гишүүд



Гансүхийн Бат-Эрдэнэ

ТУЗ-ийн гишүүн,
Санхүү хариуцсан захирал
Премиум Нэксус ХК

Гансүхийн Бат-Эрдэнэ нь Премиум Нэксус ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Санхүү хариуцсан захирал, Премиум Иннова ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Санхүү хариуцсан захирлаар ажилладаг. Тэрээр анхны ажлын гараагаа үйлдвэрлэл, худалдааны салбарт тэргүүлэгч М-Си-Эс Кока Кола ХХК-д санхүү төлөвлөлтийн газрын даргаар эхлүүлж байв. Сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд өргөн хэрэглээний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт, уул уурхай, эрчим хүч, аж үйлдвэрлэл, барилгын салбарт ажиллаж, Монголиан Майнинг Корпораци (НКЕХ: 975) болон Премиум Групп ХХК-ийн санхүүгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулсан бөгөөд М-Си-Эс Энержи ХХК-ийн дэд захирал, Монголиан Майнинг Корпорацийн Санхүү хариуцсан Дэд ерөнхийлөгчөөр ажиллаж байсан туршлагатай. Г.Бат-Эрдэнэ нь Хан-Уул Дээд Сургуулийг бизнесийн удирдлага, хэрэглээний математикч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгссөн.



Чойжин-Осорын Мөнхчимэг

ТУЗ-ийн гишүүн
Премиум Нэксус ХК

Чойжин-Осорын Мөнхчимэг нь Премиум Нэксус ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Премиум Корпорэйшний Хүний нөөц хариуцсан захирал бөгөөд олон улсын томоохон төслүүдэд тооцогдох Оюу Толгой төсөл дэх Бетон зуурмагийн үйлдвэр, Салхин сэнсний төсөл, Шинэ нисэх онгоцны барилгын төсөл, Шангри-Ла зочид буудал, худалдааны төв төслүүдэд мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжилтнүүдийг бэлтгэн, төслүүдийг амжилттай хүлээлгэн өгөхөд үнэтэй хувь нэмэр оруулсан. Мөн тэрээр 2004-2012 онуудад үндэсний томоохон групп компани болох М-Си-Эс Групп болон Энержи Ресурс ХХК-ийн Ухаа худаг салбарт Захиргаа, хүний нөөцийн алба хариуцсан менежерээр ажиллаж байсан туршлагатай. Ч.Мөнхчимэг нь Удирдлагын Академийг төрийн захиргааны удирдлагын бакалаврын зэрэгтэй төгссөн.



Ганболдын Чинзориг

ТУЗ-ийн гишүүн,
Гүйцэтгэх захирлын орлогч
Премиум Нэксус ХК

Ганболдын Чинзориг нь Премиум Нэксус ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирлын орлогч юм. Тэрээр программ хангамж, бизнес процесс, бизнес интелиженс, мэдээллийн технологийн мастер төлөвлөлт, инженерчлэлийн чиглэлээр ажилласан туршлагатай бөгөөд Мэдээллийн Технологи, Шуудан, Харилцаа Холбооны Газар (“МТШХГ”) -ын Бодлого төлөвлөлтийн газрын дарга, АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагт Эдийн засгийн бодлогын шинэчлэл ба өрсөлдөх чадварын төслийн мэдээллийн технологийн зөвлөх, Азийн Хөгжлийн Банкны Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх төсөл, Хөрөнгийн зах зээлийн мэдээллийн систем ба санхүүгийн дэд бүтцийн зөвлөхөөр тус тус ажиллаж байсан туршлагатай. Тэрээр МТШХГ-д ажиллаж байхдаа Цахим засаглал хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулж, Монгол Улсын Харилцаа холбоо, интернэт, шуудан, хэвлэл мэдээлэл, хиймэл дагуулын холбооны талаар баримтлах төрийн бодлого болон Мобайл сүлжээний 4G үйлчилгээг Монгол Улсад нэвтрүүлэх зохицуулалтын бодлогыг боловсруулсан. Г.Чинзориг нь ШУТИС-ийг компьютерын шинжлэх ухааны бакалавр, АНУ-ын Луисвиллийн Их Сургуулийг бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй төгссөн.

ТУЗ-ийн гишүүд



Болдбаатарын Бат-Эрдэнэ

ТУЗ-ийн гишүүн
Премиум Нэксус ХК

Болдбаатарын Бат-Эрдэнэ нь Премиум Нэксус ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Польшийн Хөгжлийн Сангийн Хөрөнгө Оруулалт Худалдааны Агентлагийн Монгол дах суурин төлөөлөгч, Хорайзон Партнерс ХХК-ийн үүсгэн байгуулагч бөгөөд хөрөнгө оруулалт, олон улсын хамтын ажиллагаа, худалдааны чиглэлээр 16 гаруй жил ажилласан туршлагатай. Тэрээр Польш, АНУ, Швейцар улсад сурч, Монголын анхны гадаадын (Японы) хөрөнгө оруулалтын банканд зах зээлийн шинжээчээр, Олон Улсын Санхүүгийн Корпорац болон Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкны хөрөнгө оруулалттай Монголын анхны хаалттай хөрөнгө оруулалтын санд (50 сая ам. долларын) зах зээл, бизнесийн шинжээчээр, Польш-Монголын хамтарсан худалдааны компанийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан ба Азийн Хөгжлийн Банкны Монгол улсад “Private Equity” болон “Venture Capital” хөрөнгө оруулалтын сангийн зах зээлийг хөгжүүлэх техник эдийн засгийн үндэслэл боловсруулах зөвлөх компаниар ажилласан хөрөнгө оруулалт, стратеги, менежментийн зөвлөх үйлчилгээний компанийн үүсгэн байгуулагч юм. Б.Бат-Эрдэнэ нь Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийг нягтлан бодох бүртгэлийн бакалаврын зэрэгтэйгээр төгссөн.



Өлзийсүрэнгийн Эрдэнэчимэг

ТУЗ-ийн хараат бус гишүүн
Премиум Нэксус ХК

Өлзийсүрэнгийн Эрдэнэчимэг нь Премиум Нэксус ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн бөгөөд нийгэм, эдийн засаг, байгаль орчин, хөдөө аж ахуй, эрүүл мэндийн чиглэлээр дагнан судалгаа, үнэлгээ хийдэг Когнос Интернэйшнл ХХК-ийн Захирал, үүсгэн байгуулагч юм. Тэрээр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын Хүүхдийн сан, НҮБ-ын Хүн амын сан, Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк, ЮНЕСКО, Европын холбоо гэх мэт олон улсын байгууллагууд болон төр, хувийн хэвшлийн бодлого, хөтөлбөр, стратеги мөн Тогтвортой хөгжлийн зорилгын судалгаа, үнэлгээ дээр сүүлийн 14 жил ажиллаж байна. Эрдэнэчимэг нь Монголын үнэлгээний холбооны үүсгэн байгуулагч, ТУЗ-ын дарга бөгөөд Америкийн үнэлгээний холбоо, Монголын үнэлгээний холбооны Нийгмийн нөлөөллийн хэмжилт ба Байгаль орчин, нийгэм, засаглалын салбар бүлгийн гишүүн, Үнэлгээний хамтын ажиллагааны төлөөх олон улсын байгууллага (IOCE), Ази номхон далайн үнэлгээний холбоо (APEA)-ны Үнэлгээг мэргэжлийн түвшинд хөгжүүлэх ажлын хэсгийн гишүүнээр тус тус ажилладаг. Эрдэнэчимэг нь МУИС-д хүн амзүйн докторант ба Английн Лондоны Эдийн Засгийн Сургуульд нийгмийн судалгааны аргазүйн магистр, Тайландын Махидолын Их Сургуульд хүн ам, нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгааны магистр зэрэг тус тус хамгаалсан.



Ванчигийн Ганзориг

ТУЗ-ийн хараат бус гишүүн
Премиум Нэксус ХК

Ванчигийн Ганзориг нь Премиум Нэксус ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн бөгөөд стратеги ба коммуникацийн чиглэлээр мэргэшсэн Бат Солюшн Партнерс ХХК-ийн Удирдах зөвлөлийн дарга, “СЕО” клубийн ерөнхийлөгч, Монголын Дауны Холбоо, Менторшипийн залуу мэргэжилтнүүдийн хөтөлбөрийн тэргүүн, Монголын Тусгай Олимпын Хорооны Удирдах зөвлөлийн гишүүн, “Global Teacher Prize”-ийн академийн гишүүн, Синдикат ярилцлага нэвтрүүлгийн модератор, тэргүүлэх мэдээллийн сайтуудын нийтлэлчээр ажилладаг. Тэрээр Худалдаа Хөгжлийн Банк, ХасБанк, МОСДАК, Шунхлай Группийн удирдлагын багт ажиллаж байсан туршлагатай бөгөөд Дэлхийн Эдийн Засгийн Форумын 2014 оны дэлхийн залуу манлайлагчаар шалгарсан. В.Ганзориг нь Японы Олон Улсын Их Сургуулийг цахим бизнесийн удирдлагын магистр, Австралийн Нотре Даме Их Сургуулийг бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй төгссөн бөгөөд АНУ (Virginia, Yale), Англи (Oxford), Өмнөд Африк (WITS, Cape Town), Сингапур (NUS) улсуудад удирдлага, манлайлал, бодлогын инновац, гео улс төр, өөрчлөлтийн менежмент чиглэлээр мэргэжлийн сургалтуудад хамрагдсан Монголын Улсын мэргэшсэн зөвлөх юм.



ТУЗ-ийн дэргэдэх хороод

Тус компани нь Компанийн тухай хуулийн 81-д заасны дагуу ТУЗ-ийн дэргэдэх хороодыг байгуулж үйл ажиллагааг нь хууль болон холбогдох журамд нийцүүлэн зохион байгуулж, тайлагнаж байна.

Мөн компанийн алсын хараа, олон улсын хандлага, туршлагыг нэвтрүүлэх үүднээс компанийн дээд удирдлага, бодлого, стратегийн түвшинд БОНЗ-ын хүрээний асуудалд анхаарч ТУЗ-ийн 2022 оны 07 тоот тогтоолоор Байгаль орчин, нийгэм, засаглалын хороог байгуулж хоёр дахь жилдээ амжилттай ажиллаж байна. Тус хорооны хувьд компанийн стратегийн шилжилтийн хүрээнд “Хамтын үнэ цэн” гэсэн суурь ойлголтын дагуу шударга, хариуцлагатай, ил тод тунгалаг байх зарчмуудыг тодорхойлж хөрөнгө оруулагч болон оролцогч талуудад БОНЗ-ын тайлагналыг боловсруулан ажилласан байна. БОНЗ-ын хорооны үндсэн чиглэл нь :

компанийн үйл ажиллагаа хүлэмжийн хийн ялгарал ба байгаль орчинд, хүлэмжийн хийн ялгарал ба байгаль орчин компанийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж байгаа,

компанийн үйл ажиллагаа хүний эрх ба нийгэмд, хүний эрх ба нийгэм компанийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж байгаа,

оролцогч талууд компанийн үйл ажиллагаа, компанийн соёлд хэрхэн нөлөөлж байгааг хянаж, удирдахаас гадна цаашдын бизнесийн тогтвортой, тасралтгүй байдлыг хангах, эрсдэлийн удирдлагыг илүү сайжруулах, хөрөнгө оруулагчдыг татахад чиглэнэ.

№	ТУЗ-ийн дэргэдэх хороод	Гишүүдийн нэр	Албан тушаал
1	Байгаль орчин, нийгэм, засаглалын хороо	Ө.Эрдэнэчимэг	Хорооны дарга, ТУЗ-ийн Хараат бус гишүүн
		Гари Биондо	ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн Хараат бус гишүүн
		Ч.Мөнхчимэг	ТУЗ-ийн гишүүн
2	Нэр дэвшүүлэх хороо	В.Ганзориг	Хорооны дарга, ТУЗ-ийн Хараат бус гишүүн
		Гари Биондо	ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн Хараат бус гишүүн
		А.Ганхуяг	ТУЗ-ийн гишүүн
3	Цалин урамшууллын хороо	Ө.Эрдэнэчимэг	Хорооны дарга, ТУЗ-ийн Хараат бус гишүүн
		Гари Биондо	ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн Хараат бус гишүүн
		А.Ганболд	ТУЗ-ийн гишүүн
4	Аудитын хороо	В.Ганзориг	Хорооны дарга, ТУЗ-ийн Хараат бус гишүүн
		Гари Биондо	ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн Хараат бус гишүүн
		Г.Бат-Эрдэнэ	ТУЗ-ийн гишүүн



Байгаль орчин, нийгэм, засаглалын хороо

БОНЗ-ын хороо нь Компанийн байгаль орчин, нийгэм, засаглал (“БОНЗ”)-ын алсын хараа, стратеги, бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэхэд хяналт тавих; БОНЗ-ын шинээр гарч ирж буй чиг хандлага, асуудлуудыг хянаж үзэх, үүний дагуу Компанийн БОНЗ-ын талаарх алсын харааг боловсруулах, заавар зөвлөмжийг өгөх; аюулгүй байдал, байгаль орчныг хамгаалах, нийгмийн хариуцлага, компанийн засаглалын талаарх Компанийн бодлогыг тодорхойлох, түүнд шаардлагатай нэмэлт өөрчлөлтүүдийг оруулах; ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх удирдлагын сургалт, тасралтгүй мэргэшлийн өсөлтөд хяналт тавих, хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагыг дагаж мөрдөх бодлого, журам, гарын авлага, ёс зүйн дүрмийг боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтийг хянах, ТУЗ болон түүний хороодын үйл ажиллагаа, ТУЗ-ийн гишүүдийн оруулсан хувь нэмрийг тогтмол үнэлж, ТУЗ-д зөвлөмж гаргах үүрэгтэй. БОНЗ-ын хороо нь ТУЗ-ийн ердийн гишүүн Ч.Мөнхчимэг, ТУЗ-ийн хараат бус гишүүд Ө.Эрдэнэчимэг, Гари Биондо нараас бүрдсэн гурван гишүүнтэй бөгөөд Ө.Эрдэнэчимэг нь тус хорооны дарга юм.

Цалин урамшууллын хороо

Цалин урамшууллын хороо нь ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын цалин урамшуулал, нөхөн олговортой холбоотой зохицуулалтыг тодорхойлох, хяналт тавих, өндөр ур чадвартай ТУЗ болон гүйцэтгэх удирдлагыг урт хугацаанд хадгалж ажиллуулах замаар хувьцаа эзэмшигчдийн ашгийг их байлгах ерөнхий зорилгын хүрээнд эдгээр эрх бүхий албан тушаалтнуудын урамшууллын хэлбэр, хэмжээ нь зохистой байгаа эсэхийг хөдөлмөрийн зах зээлийн холбогдох нөхцөл байдалд үндэслэн үнэлэх үүрэгтэй юм. Цалин урамшууллын хороо нь ТУЗ-ийн ердийн гишүүн А.Ганболд, ТУЗ-ийн хараат бус гишүүн Ө.Эрдэнэчимэг, Гари Биондо нараас бүрдсэн гурван гишүүнтэй бөгөөд Ө.Эрдэнэчимэг нь тус хорооны дарга юм.

Нэр дэвшүүлэх хороо

Нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн сул орон тоог нөхөх Компанид шаардлагатай мэдлэг, ур чадвартай нэр дэвшигчдийг олж тодорхойлох, тэдгээрийг ТУЗ-д танилцуулах, санал, зөвлөмж гаргах үүрэгтэй. Нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн гишүүн А.Ганхуяг, ТУЗ-ийн хараат бус гишүүн Гари Биондо, В.Ганзориг нараас бүрдсэн гурван гишүүнтэй бөгөөд В.Ганзориг нь тус хорооны дарга юм.

Аудитын хороо

Байгууллагад үр дүнтэй дотоод хяналтын тогтолцоог бий болгох буюу бизнесийн үр ашигтай захиран зарцуулах дотоод хяналтыг хэрэгжүүлэх, Компанийн эд хөрөнгийг хамгаалах, нягтлан бодох бүртгэлийн зохих бүртгэл хөтлөх, санхүүгийн мэдээллийн үнэн зөв, найдвартай байдлыг хангах, түүнчлэн үйл ажиллагааны гол үзүүлэлтүүдийг харьцуулах зэрэг санхүүгийн бус асуудлуудтай холбоотой бизнесийн удирдлагын дотоод хяналтын тогтолцоо, ёс зүйн хэм хэмжээг бий болгох, хадгалахад чиглэсэн санал зөвлөмжийг ТУЗ-д гаргах үүрэгтэй. Аудитын хороо нь ТУЗ-ийн ердийн гишүүн Г.Бат-Эрдэнэ болон ТУЗ-ийн хараат бус гишүүд болох В.Ганзориг, Гари Биондо нараас бүрдсэн гурван гишүүнтэй бөгөөд В.Ганзориг нь тус хорооны дарга юм.




ТУЗ-ийн хурлын үйл ажиллагаа

ТУЗ нь 2024 онд нийт 4 удаа 100 хувийн ирцтэйгээр хуралдаж 43-н шийдвэр, тогтоол гарган баталгаажуулж ажилласан байна. Хэлэлцэж шийдвэрлэсэн асуудлын агуулгуудын хүрээнд Компанийн 2023 оны санхүүгийн гүйцэтгэл, жилийн эцсийн үйл ажиллагааны тайлан, 2024 оны 1-р хагас жилийн тайлан болон 2-р хагас жилийн төлөвлөгөө, тодотгосон төсөв, 2024 оны гүйцэтгэл, 2025 оны болон урт хугацааны төлөвлөгөөг хэлэлцэн шийдвэрлэсэн бөгөөд тайлант хугацаанд Компанийн үйл ажиллагаа, гүйцэтгэх удирдлагын болон компанийн засаглалын дотоод асуудлууд, сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох, ногдол ашиг хуваарилах эсэх, охин компанийг байгуулах зэрэг төрөл бүрийн асуудлуудыг хэлэлцэн, шийдвэр тогтоол гарган ажилласан.

Түүнчлэн ТУЗ нь ТУЗ-ийн хороодын зөвлөмжийн дагуу ТУЗ-ийн болон ТУЗ-ийн хороодын үйл ажиллагааны журамд нэмэлт өөрчлөлт оруулсан.

Үйл ажиллагаа	Хэмжих нэгж	2021 он	2022 он	2023 он	2024 он
ТУЗ хуралдсан тоо	Удаа	5	7	4	4
Хурлаар хэлэлцсэн асуудлын тоо	Тоо	24	37	39	43
ГЗ-ын хурлын ирц	Хувь	100	100	100	100
Хараат бус гишүүдийн хурлын ирц	Хувь	100	100	100	100



ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

2024 онд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ болон ТУЗ-ийн хороодод засаглалын асуудлаар зөвлөгөө, мэдээлэл өгөх, Компанийн бодлогын баримт бичиг, дотоод журмын хэрэгжилтэд хяналт тавих, Компанийн хувьцаа эзэмшигчид, ТУЗ, ТУЗ-ийн хороод болон охин компаниудын ТУЗ-өөс гарах тогтоолын төслийг боловсруулах, хурлыг зохион байгуулах, хурлын тэмдэглэл хөтлөх, ТУЗ-ийн гишүүдийн сургалтыг зохион байгуулах, Компанийн үнэт цаас, түүнийг эзэмшигчдийн бүртгэлийг хөтлөх, төрийн зохицуулах болон үнэт цаасны арилжаа, төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллагатай харилцах зэрэг ажлыг хийж гүйцэтгэснээс гадна Компани болон охин компаниудын хүрээнд батлагдсан бодлогын баримт бичгийг олон улсын стандарт, олон улсад түгээмэл ашиглагддаг гэрээ конвенцэд тусгасан агуулгаар тодорхойлох, Компанийн засаглал, эрсдэлийн удирдлага, комплайнсын тогтолцооны хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тодорхойлоход шаардлагатай мэдээллийг цуглуулж, зөрүүний шинжилгээ хийсэн бөгөөд цаашид нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх, санал, зөвлөмж боловсруулах, ТУЗ болон ТУЗ-ийн хороодын үйл ажиллагааг үр дүнтэй явуулах ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөөд байна.

Эрх бүхий албан тушаалтан

ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал, Гүйцэтгэх захирлын орлогч, Санхүү хариуцсан захирал нь Компанийн эрх бүхий албан тушаалтнууд юм. Компанийн эрх бүхий албан тушаалтнуудад 2024 онд олгосон сарын цалин урамшууллын хэмжээг татварын өмнөх үнийн дүнгээр багцлан доорх хүснэгтэд харуулав.

Сарын үндсэн цалингийн хэмжээ (төгрөг)	Эрх бүхий албан тушаалтны тоо
10,000,001 болон түүнээс дээш	3
5,000,001 – 10,000,000	1
0 – ≤5,000,000	6



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС

Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан 2024 оны 1-р хагас жилийн Компанийн засаглалын кодексийн үнэлгээний тайланд дурдсанаар Премиум Нэксус ХК нь нээлттэй хувьцаат компаниуд дундаас компанийн засаглалын үнэлгээгээр тэргүүлэгч ТОП 20 компанид орж байгаа бөгөөд Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн үнэлгээгээр 7-р байранд орсон байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар Компани нь кодексийн гүйцэтгэлийн хэрэгжилт 93.3 хувь байсан хэмээн дүгнэсэн.

Компани нь 2024 онд засаглал аа сайжруулах зорилгоор өөрийн Засаглал, эрсдэлийн менежмент, комплайнсын тогтолцооны нөхцөл байдлыг хөндлөнгийн байгууллагаар үнэлүүлсэн бөгөөд тус үнэлгээний тайланд дурдсаны дагуу холбогдох сайжруулалтын ажлыг эхлүүлээд байна.

Агуулга	Авбал зохих нийт оноо	Авсан оноо, 2023	Үнэлгээний хувь, 2023	Авсан оноо, 2024	Үнэлгээний хувь, 2024
ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	12	100%	8	67%
ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	9	90%	9	90%
Тайлагнал, мэдээллийн ил тод байдал	6	6	100%	5	83%
Аудит, хяналтын тогтолцоо	6	5	83%	6	100%
Эрсдэлийн удирдлага	8	8	100%	8	100%
Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшуулал	6	6	100%	6	100%
Оролцогч талуудын эрх ашиг	8	8	100%	8	100%
Компанийн соёл	6	6	100%	6	100%
Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	9	90%	10	100%
Нэгдсэн дүн	72	69	95%	66	93%



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУДАД ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМЭР



Нэгдсэн Үндэстний Байгууллагын санаачлан хэрэгжүүлж буй Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ) нь хүн төрөлхтөнд илүү сайхан, тогтвортой ирээдүйд хүрэхийн тулд хөгжлөөс хэнийг ч үл хоцроож, үлдээхгүйн төлөөх чин эрмэлзэлд тэмүүлсэн дэлхий нийтийн, хамтын хүчин чармайлт юм. Даян дэлхийн улс орон бүр амлалт өгсөн ТХЗ-н баримт бичиг нь 17 зорилго, 169 зорилтын хүрээнд ядуурал, тэгш бус байдал, уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтол, энх тайван, шударга ёс зэрэг зорилтуудыг авч үздэг. ТХЗ-ийг биелүүлэхэд бүх оролцогч талуудын үүрэг амлалт, хүчин чармайлт чухал бөгөөд Премиум Нэксус ХК нь бизнесийн стратеги, бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дамжуулан хамгийн их нөлөө үзүүлж чадна гэж үзэж буй өөрийн ТХЗ-уудыг тодорхойлсон.



Премиум Нэксус ХК нь 2023 онд 374 салбартай байсан бол 2024 онд 12 аймагт 29 шинэ салбар дэлгүүр нээж, 60 ажлын байр шинээр бий болгож, үйл ажиллагаагаа өргөжүүлсэн бөгөөд одоогоор Улаанбаатар хотод 396, орон нутагт 49, нийт 445 салбар дэлгүүртэйгээр үйл ажиллагаа явуулж байна.



2024 онд нийт 445 гаруй салбар дэлгүүрээр өдөр бүр 180,000 орчим үйлчлүүлэгч үйлчлүүлж, 80,400 гаруй ширхэг бэлтгэсэн хоол борлуулсан бөгөөд сүлжээ дэлгүүрийн хэмжээнд борлуулагдаж буй нийт хоолны 44,8 хувийг СУ хоолны үйлдвэрт үйлдвэрлэдэг бол 55.2 хувийг дотоодын хоол үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүд нийлүүлдэг байна.



2024 онд Премиум Нэксус ХК-ийн хувьд нийт 21 хоол бэлтгэн нийлүүлэгчтэй хамтран ажиллаж байгаа ба нийт нийлүүлэгчийн 52% нь HACCP баталгаажилт орсон байна.

- 11 нийлүүлэгч HACCP стандартыг хэрэгжүүлж баталгаажилтын гэрчилгээ авсан
- 5 нийлүүлэгч Хамтдаа хөгжье 4 хөтөлбөрт хамрагдан 2025 оны эхний улиралд баталгаажуулалтад орохоор бэлтгэж байна.
- 4 нийлүүлэгч бие даан HACCP стандартыг хэрэгжүүлэн ажиллаж байна.
- 1 нийлүүлэгч HACCP хэрэгжүүлэлт хийгдээгүй байна.
- 2025 оны эхний улиралд нийт нийлүүлэгчийн 90 хувь нь HACCP стандарт хэрэгжүүлсэн байхаар төлөвлөн ажиллаж байна.



Mongolian Labor Market Summit-ын “Good Workplace Awards 2024” Премиум Нэксус ХК-ийг “BEST TRAINING – СУРГАЛТ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИГЧ ШИЛДЭГ АЖИЛ ОЛГОГЧ”- оор шалгаруулав.

- 2023-2024 онд сургалтын баг 22,919 ажилтанд 122,981 хүн цагийн сургалтыг 830 удаагийн давтамжтай хүргэжээ.
- 2023-2024 онд сургалтад суусан ажилтнуудаас 1,293 ажилтан карьер зэрэглэл хөндлөн чиглэлд ахисан бол босоо чиглэлд 387 хүн албан тушаал дэвшсэн.



2024 оны тоо баримтаас харахад Премиум Нэксус ХК-ийн нийт ажилтнуудын 70,5% нь эмэгтэй, 29.5% нь эрэгтэй байна. Удирдлагын түвшин дэх хүйсийн харьцааг авч үзвэл эмэгтэй ажилтны эзлэх хувь анхан, дунд удирдах түвшинд 50%, гүйцэтгэх удирдлагын түвшинд эрэгтэй ажилтны эзлэх хувь 53.3% байна. Эрэгтэй, эмэгтэй ажилчдын цалингийн харьцаа бүх түвшинд 1:1 байна.



CU 445 салбараар эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн үйлчилгээгээр хангаж, ус хэмнэх мэдрэгчтэй угаалтуур болон суултуурын усны таталтыг 50% -р бууруулсан арга хэмжээ авсан. Үйл ажиллагаандаа ус хэмнэлттэй технологийг суурилуулах арга хэмжээг авснаар 1 сая төгрөг тутам дах борлуулалтад ноогдох усны хэрэглээг өмнөх жилээс 31 литрээр бууруулж чадлаа.



Эрчим хүчний хэрэглээг БОНЗ суурь жил болох 2020 онтой харьцуулахад 1 сая төгрөгийн борлуулалт хийхэд зарцуулдаг эрчим хүчний хэрэглээ 2.9 дахин буурсан байна.



Богинсгосон эсвэл бүтэн цагаар хөдөлмөр эрхэлж буй оюутан залуучууд 50 гаруй хувийг эзэлж байгаа бөгөөд дийлэнх олонх нь 18-34 насны залуучууд байна. Компанийн зүгээс ажилтны аюулгүй байдлыг хангахад чиглэсэн олон арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд: Бүх дэлгүүрийг камержуулж, салбар дэлгүүрүүдэд гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөө боловсруулж, галын тохижилтын арга хэмжээ авч ажилласан. Харуул хамгаалалтын компанитай гэрээ байгуулж хамгаалалт дуудах товчийг дарснаас хойш 10 минутын дотор хамгаалалтын баг ирдэг. CU хоолны үйлдвэр, 2 түгээлтийн төвүүдийн ажилтнууд, оффисын 7 хоног бүр гадуур тогтмол явдаг ажилтнууд гэнэтийн ослын даатгалт хамрагддаг. ХАБЭА сургалт, спортын тэмцээнийг тогтмол зохион байгуулдаг бөгөөд нэг бүрийн хамгаалах хэрэгслээр тогтмол хангадаг.



- Нийт 830,000 бүртгэлтэй хэрэглэгч, өдөр тутмын 230,000 идэвхтэй хэрэглэгчтэйгээр хөгжиж буй CU аппликэйшнийг хөгжүүлсэн.
- CU нийлүүлэгчдийн Vendor Portal, ажилтнуудын Employee Portal, хүргэлтийн захиалга хүлээн авах бүртгэх систем, үйл ажиллагааны үндсэн системүүдийн хоорондын интеграцийн хөгжүүлэлт болон байнгын хэвийн ажиллагаа, нэмэлт сайжруулалтыг хангаж ажиллан, Монголын хэрэглэгчдэд дэвшилтэт технологийн шийдлүүдийг хүргэсээр байна.
- Stora V2.0 Үүсгэн байгуулагдсаны 3 жилийн ойгоо угтан Стора Централ ХХК нь системийн бүрэн шинэчлэлтээ хийн V2.0 хувилбараа танилцуулав. Уг шинэчилсэн хувилбар нь хэрэглэгчид илүү ойлгомжтой дизайн, процесс болон хэрэглэгчдийн эрэлт хүсэлтэд нийцсэн цоо шинэ 6 дэлгүүр болох Ikea, Apple, Costco, Sephora, Nike, Victoria Secret-ийг нэгтгэв.



2024 оны байдлаар Премиум Нэксус ХК-д хөгжлийн бэрхшээлтэй ажилтан нийт үндсэн ажилтны 8,9%-ийг эзэлж байгаа нь Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.2 дах заалт буюу хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар ажил олгогчид тавьдаг үүрэгтэй бүрэн нийцэж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу богиносгосон цагаар ажилладаг. Ажлын байрны зарыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй түгээх үүднээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоонуудтай хамтарч ажилладаг.



- Насанд хүрээгүй хүүхдэд насны хязгаарлалттай бүтээгдэхүүн болох электрон болон утаат тамхи, согтууруулах ундаа худалдан авахаас урьдчилан сэргийлж иргэний бичиг баримтыг шалган худалдаалахад уриалсан “Үзүүлээд Өгье” аяныг хэрэгжүүлсэн.
- “Соёл танаас эхэлнэ” нийгмийн аяныг Цагдаагийн Ерөнхий Газар CU болон GS25-тай хамтран амжилттай хэрэгжүүлсэн. Энэхүү аян нь нийтийн соёл ёс суртахууныг дээшлүүлж, илүү эелдэг, бусадтай илүү хүндэтгэлтэй харилцдаг сайхан нийгмийг бүтээхэд олон нийтийг уриалсан бөгөөд давхардсан тоогоор 65,278,300 хүнд хүрсэн томоохон аяны нэг болсон.



Стора Централ ХХК нь Тогтвортой хөгжлийн 17 зорилгын хүрээнд StoreForGood төслийг эхлүүлж, хог хаягдлыг багасгах, байгальд ээлтэй хэрэглээг дэмжих зорилготой ажиллаж байна. Уг төсөл нь хүмүүсийн хамгийн дутуу хэрэглэн хаядаг, хэрэгцээгүй худалдан авалт их хийдэг, үйлдвэрлэх нөөц болон байгальд шингэх хор хөнөөл ихтэй бүтээгдэхүүнийг хоорондоо солилцон хэрэглэх замаар насыг нь уртасгаж хог хаягдлыг багасгах зорилготой бөгөөд стора.мн болон сторабоксын дэд бүтцийг ашиглан ном, хүүхдийн тоглоом, хувцас зэрэг эд зүйлсийг солилцох боломжийг олгодог. Цаашид солилцох бүтээгдэхүүний хүрээг нэмэгдүүлж, хэрэглээг уртасгах, эд хэрэгслийн хор хөнөөлийг бууруулах шинэ трендийг хөгжүүлэхээр зорьж байна.



2024 онд хүргэлтийн үйлчилгээг өглөөний 04:00-08:00 цагийн хооронд тээвэрлэх үйл ажиллагааг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна. Хотын зүүн хэсэгт байрлах хүйтэн хэлхээний түгээлтийн төвөөр дамжуулан хөргүүр бүхий машинаар өдөр бүр 80,000-100,000 хүнсний бүтээгдэхүүнийг, баруун өмнөд хэсэгт байрлах ердийн түгээлтийн төвөөс энгийн ачааны машинаар өдөр тутмын хүнсний бүтээгдэхүүнийг салбар дэлгүүрүүдэд хүргэж байна.

Энэхүү хүргэлтийн хөдөлгөөний зохицуулалтын үр дүнд тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөний тоог эрс багасгаж, түгээлтийн цагаа түгжрэлгүй үеэр зохион байгуулснаар тээвэрлэлтийн хугацааг 4 дахин богиносгож, шатахуун зарцуулалтыг 80%-иар бууруулан, агаарын бохирдол болон хүлэмжийн хийн ялгарлыг мэдэгдэхүйц багасган ажиллаж байна.



Дэлгүүр бүрд төрөлжүүлсэн хогийн сав байрлуулж, хоолны хаягдлыг гахайн фермд, ашигласан тосыг савангийн үйлдвэрт, цаасан хайрцаг рулоныг дахин боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлдэг. Бусад дахин ашиглагдах боломжгүй хог хаягдлыг гэрээт тохижилт үйлчилгээний компаниуд долоо хоног бүр ачиж, ариутгал халдваргүйжүүлэлт тогтмол хийдэг.



Зээлийн батлан даалтын сан нь Капитрон банк, Премиум Нексус ХК-тай хамтран СИ конвинеенс дэлгүүрийн франчайз эрхийг хөнгөлөлттэй, батлан даалттай зээлээр авах боломжийг бүрдүүлж, 20 бизнес эрхлэгч эмэгтэйд нийт 2 тэрбум төгрөгийн зээл олгоод байна. Жилийн 8.88%-ийн хүүтэй, 100 сая хүртэлх төгрөгийн зээл нь эмэгтэй бизнес эрхлэгчдэд богино хугацаанд хувийн бизнес эхлүүлэх боломжийг олгож, жендерийн тэгш байдлыг хангахад чиглэсэн томоохон алхам болсон бөгөөд түншлэл нь Монголын уламжлалт бизнесийн хэв маягийг өөрчилж, эмэгтэйчүүдийн манлайллын шинэ жишиг тогтоож, 2024 онд орон нутгийн эмэгтэй бизнес эрхлэгчдэд зээлийн хүрэлцээг нэмэгдүүлэхээр ажиллаж байна.




САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Санхүүгийн гүйцэтгэл	1
Нэгтгэсэн орлого, үр дүнгийн товч тайлан	1
Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан	1
Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	1




Санхүүгийн гүйцэтгэл


Цэвэр борлуулалт
(сая төгрөгөөр)




Татварын дараах ашиг, алдагдал
(сая төгрөгөөр)



Нийт сүлжээний борлуулалт
(сая төгрөгөөр)



Үйл ажиллагааны мөнгөн урсгал
(сая төгрөгөөр)






Нэгтгэсэн орлого, үр дүнгийн товч тайлан

Мянган төгрөгөөр	2019	2020	2021	2022	2023	2024
Борлуулалтын орлого	37,468	45,348	94,038	261,019	390,497	598,379
Борлуулалтын өртөг	(43,356)	(50,707)	(101,051)	(265,272)	(393,363)	518,273
Нийт ашиг (алдагдал)	(5,888)	(5,359)	(7,013)	(4,253)	(2,866)	80,106
Нийт ашиг (алдагдал)-н маржин	(15.71)%	(11.82)%	(7.46)%	(1.63)%	(0.73)%	13.39 %
Үйл ажиллагааны зардал	(2,202)	(5,019)	(9,669)	(11,919)	(14,096)	(12,878)
Үйл ажиллагааны ашиг (алдагдал)	(8,090)	(10,378)	(16,682)	(16,172)	(16,962)	67,228
Үйл ажиллагааны ашиг (алдагдал)-н маржин	(21.59)%	(22.89)%	(17.74)%	(6.20)%	(4.34)%	11.24 %
Санхүүгийн орлого	7	159	1,430	1,228	1,137	2,562
Санхүүгийн өртөг	(3,191)	(5,705)	(5,700)	(11,148)	(17,506)	(19,438)
Татварын өмнөх ашиг	(11,274)	(15,924)	(20,952)	(26,092)	(33,332)	50,352
Татварын зардал	(1)	196	11	407	626	(2,950)
Татварын дараах цэвэр ашиг (алдагдал)	(11,275)	(15,728)	(20,941)	(25,684)	(32,706)	47,402
Цэвэр ашиг (алдагдлын) маржин	(30.09)%	(34.68)%	(22.27)%	(9.84)%	(8.38)%	7.92 %



Ашигт ажиллагааны харьцаа
үзүүлэлтүүд, %

Компанийн ашигт ажиллагааны маржин харьцаануудын сүүлийн 5 жилийн трендийг харахад өсөх тренд ажиглагдаж байгаа ба 2020 онд нийт ашгийн маржин -11.8% байсан бол 2024 оны байдлаар 13.4% болж ашигт ажиллагаанд хүрсэн.





Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

(Мянган төгрөгөөр)	2022	2023	2024
Эргэлтийн бус хөрөнгө	44,439,908	40,170,281	78,428,993
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	4,280,725	2,980,585	10,431,533
Дансны ба бусад авлага	4,489,855	3,675,977	10,329,858
Бараа материал	31,838,373	28,250,029	47,194,508
Бусад эргэлтийн бус хөрөнгө	3,830,955	5,263,690	10,473,094
Эргэлтийн бус хөрөнгө	126,608,767	153,324,575	235,502,459
Үндсэн хөрөнгө	67,338,093	84,451,983	118,133,460
Биет бус хөрөнгө	5,854,517	5,744,456	39,774,043
Ашиглах эрхтэй хөрөнгө	46,960,531	50,532,242	60,568,629
Бусад эргэлтийн бус хөрөнгө	6,455,626	12,595,894	17,026,327
НИЙТ ХӨРӨНГӨ	171,048,675	193,494,856	313,931,452
Богино хугацаат өр төлбөр	73,761,640	116,172,882	116,242,644
Дансны ба бусад өглөг	47,085,498	81,166,900	66,899,736
Зээл	17,280,869	19,969,946	24,733,230
Бусад богино хугацаат өр төлбөр	1,489,810	15,036,036	24,609,678
Урт хугацаат өр төлбөр	78,849,414	91,590,656	94,899,999
Урт хугацаат зээл	27,932,886	33,882,015	23,389,243
Бусад хугацаат өр төлбөр	50,916,528	57,708,641	71,510,756
Эздийн өмч	18,437,621	(14,268,682)	102,788,809
Энгийн хувьцаа	81,776,864	81,776,864	111,425,203
Нэмж төлөгдсөн капитал	13,820,503	13,820,503	45,757,916
Эздийн өмчийн бусад хэсэг	318,731	318,731	9,192,109
Хуримтлагдсан алдагдал	(77,478,477)	(110,184,780)	(63,586,419)
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	171,048,675	193,494,856	313,931,452




Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Сая төгрөгөөр)	2022	2023	2024
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлогын дүн (+)	291,091.9	429,705.3	698,620.5
Мөнгөн зарлагын дүн (-)	(299,491.7)	(427,286.4)	(637,707.0)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(8,399.8)	2,418.9	60,913.5
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлогын дүн (+)	17,170.6	109.2	3,152.3
Мөнгөн зарлагын дүн (-)	(30,915.5)	(33,646.3)	(40,723.4)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(13,744.9)	(33,537.1)	(37,571.1)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлогын дүн (+)	42,842.0	33,906.6	70,712.9
Мөнгөн зарлагын дүн (-)	(20,204.2)	(31,903.1)	(86,473.0)
Хоорондын тооцоо (+/-)	-	27,920.7	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн гадаад валютын ханшийн зөрүү	(273.6)	(106.0)	(131.2)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(219.6)	(1,300.1)	7,450.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,061.2	4,280.7	2,980.6
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,280.7	2,980.6	10,431.5



Хувьцааны үнийн хөдөлгөөн
2024 он

2024 оны 12-р сарын 31-ы байдлаар Компанийн зах зээлийн үнэлгээ 232 тэрбум төгрөг байсан ба МХБ-ийн зах зээлийн үнэлгээгээр 11-р байранд эрэмбэлэгдэж, нийт зах зээлийн 1.79 хувийг бүрдүүлж байна. Компанийн MSE:CUMN хувьцаа нь 2024 онд МХБ-ийн хувьцааны арилжааны үнийн дүнгийн эрэмбээр 9-д, арилжаалагдсан тоо ширхгийн эрэмбээр 4-т тус тус жагссан. 2024 оны байдлаар МХБ-ийн хоёрдогч зах зээлийн хувьцааны арилжааны үнийн дүнгийн 3.1 хувийг эзэлж байсан байна.



Премиум Нэксус ХК-ийн зах зээлийн үнэлгээ	232,332,691,609
МХБ-д бүртгэлтэй компаниудын зах зээлийн нийт үнэлгээ	12,993,223,761,156
Эзлэх хувь	1.79 %

МХБ-ийн хоёрдогч зах зээлийн хувьцааны арилжааны дүн	317,522,241,254
Хувьцааны арилжаа үнийн дүнгээр	9,835,251,338
Эзлэх хувь	3.10 %



САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Дэлгэрэнгүй орлогын тайлан	1
Санхүүгийн байдлын тайлан	1
Мөнгөн гүйлгээний тайлан	1
Өмчийн өөрчлөлтийн тайлан	1



Дэлгэрэнгүй орлогын тайлан

	Нэгтгэсэн	Нэгтгэсэн
Мянган төгрөгөөр	2024 он	2023 он
Борлуулалтын орлого	598,378,660	390,496,597
Борлуулалтын өртөг	(518,272,786)	(393,362,620)
Нийт ашиг/(алдагдал)	80,105,874	(2,866,023)
Ерөнхий, захиргааны болон борлуулалтын зардал	(34,803,106)	(17,130,606)
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдал	(566,913)	(37,447)
Бусад олз, цэвэр	21,864,014	3,054,660
Бусад орлого	628,384	17,070
Үйл ажиллагааны ашиг/(алдагдал)	67,228,253	(16,962,346)
Санхүүгийн зардал	(19,438,179)	(17,506,483)
Санхүүгийн орлого	2,562,377	1,136,615
Орлогын албан татварын өмнөх ашиг/(алдагдал)	50,352,451	(33,332,214)
Орлогын албан татварын (зардал)/өгөөж	(2,949,957)	625,911
ТАЙЛАНТ ЖИЛИЙН АШИГ/(АЛДАГДАЛ)	47,402,494	(32,706,303)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
ТАЙЛАНТ ЖИЛИЙН НИЙТ ДЭЛГЭРЭНГҮЙ АШИГ/(АЛДАГДАЛ)	47,402,494	(32,706,303)
Ногдох:		
Толгой компанийн эзэмшигчдэд	46,598,361	(32,706,303)
Хяналтын бус хувьд оролцоонд	804,133	-
	47,402,494	(32,706,303)
Группийн хувьцаа эзэмшигчдэд хамаарах нэгж энгийн хувьцаанд ногдох үргэлжилж буй үйл ажиллагааны суурь болон хорогдуулсан ашиг/(алдагдал), (нэгж хувьцаанд ногдох төгрөг)	42	(40)



Санхүүгийн байдлын тайлан

Мянган төгрөгөөр	Нэгтгэсэн	Нэгтгэсэн
	2024 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	118,133,460	84,451,983
Ашиглах эрхтэй хөрөнгө	60,568,629	50,532,242
Биет бус хөрөнгө ба гүдвил	39,774,043	5,744,456
Санхүүгийн түрээсийн авлага	10,031,970	8,238,816
Зээлийн авлага	47,049	-
Урьдчилгаа	2,580,879	770,655
Дансны ба бусад авлага	2,381,209	2,160,078
Хойшлогдсон татварын хөрөнгө	1,985,220	1,426,574
Нийт эргэлтийн бус хөрөнгө	235,502,459	153,324,804
Эргэлтийн хөрөнгө		
Зээлийн авлага	27,599	2,000,000
Бараа материал	47,194,508	28,250,029
Урьдчилгаа	7,326,359	1,761,313
Дансны ба бусад авлага	10,329,858	3,675,977
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	10,431,533	2,980,585
Санхүүгийн түрээсийн авлага	3,119,136	1,502,377
Нийт эргэлтийн хөрөнгө	78,428,993	78,428,993
НИЙТ ХӨРӨНГӨ	313,931,452	193,495,085



Мянган төгрөгөөр

Нэгтгэсэн

Нэгтгэсэн

2024 оны 12-р сарын 31

2023 оны 12-р сарын 31

ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ

Хувьцаат капитал	111,425,203	81,776,864
Нэмж төлөгдсөн капитал	45,757,916	13,820,503
Эздийн өмчийн бусад хэсэг	318,731	318,731
Хуримтлагдсан алдагдал	-63,586,419	-110,184,780
Группийн эзэмшигчдэд ногдох өмч	93,915,431	-14,268,682
Хяналтын бус хувь оролцоо	8,873,378	-
НИЙТ ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	102,788,809	-14,268,682

ӨР ТӨЛБӨР**Урт хугацаат өр төлбөр**

Түрээсийн өр төлбөр	64,535,185	56,622,145
Зээл	23,389,243	33,882,015
Засгийн газрын тусламж	498,904	-
Бусад урт хугацаат өр төлбөр	1,834,721	709,269
Гэрээний өр төлбөр	43,388	117,781
Хойшлогдсон татварын өр	4,598,558	259,675
НИЙТ урт хугацаат өр төлбөр	94,899,999	91,590,885

Богино хугацаат өр төлбөр

Түрээсийн өр төлбөр	17,695,275	12,079,710
Зээл	24,733,230	19,969,946
Засгийн газрын тусламж	627,087	-
Бусад татварын өглөг	2,138,926	1,669,598
Дансны ба бусад өглөг	66,899,736	81,166,900
Гэрээний өр төлбөр	1,457,762	1,245,531
Орлогын албан татварын өглөг	2,690,628	41,197
НИЙТ богино хугацаат өр төлбөр	116,242,644	116,172,882

НИЙТ ӨР ТӨЛБӨР

211,142,643

207,763,767

НИЙТ ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР

313,931,452

193,495,085



Мөнгөн гүйлгээний тайлан

Мянган төгрөгөөр	Нэгтгэсэн 2024	Нэгтгэсэн 2023
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:		
Татварын өмнөх ашиг/(алдагдал)	50,352,451	(33,332,214)
Тохируулгууд:		
Үндсэн хөрөнгийн элэгдэл	19,174,982	14,670,795
Үндсэн хөрөнгө борлуулсны (олз)/ гарз, цэвэр	(7,492)	27,867
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	105,233	161,633
Биет бус хөрөнгийн хорогдуулга	1,282,756	1,136,540
Засгийн газрын тусламжийн хорогдуулга	375,324	-
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз	566,913	37,447
Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдэл	12,649,118	11,749,379
Ашиглах эрхтэй хөрөнгө данснаас хассаны олз	(1,899,749)	(1,722,713)
Гадаад валютын ханшийн зөрүүнээс үүссэн (олз)/гарз	(45,856)	22,417
Хөрөнгө оруулалт борлуулсны олз	-	(342,907)
Тохиролцоот худалдан авалтын олз	(19,476,657)	-
Санхүүгийн орлого	(2,190,139)	(1,136,615)
Санхүүгийн зардал	18,861,121	17,255,606
Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	79,748,005	8,527,235
Ажлын капиталын өөрчлөлт:		
Бараа материал	(14,263,111)	3,588,344
Урьдчилгаа	(4,521,123)	1,551,938
Дансны ба бусад авлага	(1,516,398)	394,541
Бусад татварын өглөг	178,483	802,118
Дансны ба бусад өглөг	11,530,289	3,195,250
Гэрээний өр төлбөр	1,202,403	495,894
Ажлын капиталын өөрчлөлтийн дараах үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	72,358,548	18,555,320
Зээлийн хүүгийн төлөлт	(7,025,530)	(6,805,263)
Орлогын албан татварын төлөлт	(1,014,039)	(39,769)
Түрээсийн өр төлбөрийн хүүгийн төлөлт	(11,916,941)	(10,292,530)
Хүлээн авсан хүү	2,190,139	895,085
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	54,592,177	2,312,843



Мянган төгрөгөөр	Нэгтгэсэн	Нэгтгэсэн
	2024	2024
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Худалдаж авсан үндсэн хөрөнгө	(36,332,729)	(36,332,729)
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	1,169,847	1,169,847
Худалдаж авсан биет бус хөрөнгө	(1,821,912)	(1,821,912)
Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
Санхүүгийн түрээсийн авлагын төлөлт	2,418,645	2,418,645
Охин компани борлуулсны орлого	1,034,381	1,034,381
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(33,531,768)	(33,531,768)
Энгийн хувьцаа гаргаж авсан санхүүжилт	2,367,049	2,367,049
Хүлээн авсан зээл	63,371,715	63,371,715
Зээлийн эргэн төлөлт	(66,526,553)	(66,526,553)
Түрээсийн өр төлбөрийн төлөлт	(13,085,709)	(13,085,709)
Зээлийн авлагын эргэн төлөлт	400,000	400,000
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(13,873,498)	(13,873,498)
Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө	(135,962)	(135,962)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өөрчлөлт	7,586,910	7,586,910
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,980,585	2,980,585
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	10,431,533	10,431,533



Өмчийн өөрчлөлтийн тайлан

Мянган төгрөгөөр	Энгийн хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан алдагдал	Нийт	Хяналтын бус хувь оролцоо	Нийт эзэмшигчдийн өмч
2023 оны 1 дүгээр сарын 1-ний үлдэгдэл	81,776,864	13,820,503	318,731	(77,478,477)	18,437,621	-	18,437,621
Тайлант жилийн алдагдал	-	-	-	(32,706,303)	(32,706,303)	-	(32,706,303)
2023 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	81,776,864	13,820,503	318,731	(110,184,780)	(14,268,682)	-	(14,268,682)
Тайлант жилийн ашиг	-	-	-	46,598,361	46,598,361	804,133	47,402,494
Гаргасан энгийн хувьцаа	29,648,339	32,020,206	-	-	61,668,545	2,367,049	64,035,594
Хяналтын бус хувь оролцоотой охин компанийн хөрөнгө оруулалт	-	-	-	-	-	5,702,196	5,702,196
Ажил гүйлгээний зардал	-	(82,793)	-	-	(82,793)	-	(82,793)
2024 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	111,425,203	45,757,916	318,731	(63,586,419)	93,915,431	8,873,378	102,788,809

Премиум Нэксус ХК
Үйл ажиллагааны тайлан

2024

Премиум Нэксус ХК
Үйл ажиллагааны тайлан

2024




Премиум Нэксус ХК
Үйл ажиллагааны тайлан

2024


Учирч болзошгүй эрсдэлүүд

Брендийн нэр хүндийн эрсдэл:



Олон улсын франчайз эрх эзэмшиж буйн хувьд үйлчилгээний стандарт алдагдаж брэндийн нэр хүнд унах, харилцагчдын итгэлийг алдах нэр хүндийн эрсдэл үүсэх магадлалтай. Нэр хүндийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор Компани нь хэрэглэгчтэй шууд харилцдаг дэлгүүрийн ажилтнуудад QSC үйлчилгээний стандартын сургалтыг тогтмол явуулж, хэрэглэгчийн гомдол, саналыг нээлттэй хүлээн авах, барагдуулах харилцагчийн үйлчилгээний төвийг ажиллуулах замаар эрсдэлийг бууруулан ажилладаг.

Хууль зүйн орчин, журмын тогтворгүй байдлын эрсдэл:




Жижиглэн худалдааны бизнес, тэр дундаа ая тухтай дэлгүүрийн бизнесийн үйл ажиллагаанд шууд нөлөөлөх хууль эрх зүйн орчны зохицуулалтын уялдаа холбоогүй, тогтворгүй байдал компанийн дунд болон урт хугацааны шийдвэрт ойлгомжгүй байдал үүсгэх эрсдэлтэй. Иймд бид холбогдох хууль тогтоомж, стандарт, захирамж болон бизнесийн хэв шинжийг уялдуулан бизнес төлөвлөгөө, стратеги боловсруулан төлөвлөх замаар уг эрсдэлийг бууруулан ажилласан.

Нийлүүлэлтийн сүлжээ тасалдах эрсдэл:




445 CU конвиниенс сүлжээ дэлгүүрүүдээр дамжуулан **+59 сая** худалдан авалтыг найдвартай, байнгын бараа бүтээгдэхүүнээр хангаж, хэрэглэгчдэд хэзээд хүссэн барааг нь бэлэн байлгах асар том дэд бүтцийн хувьд хамгийн том эрсдэл бол нийлүүлэлтийн шугам доголдох эрсдэл юм. Бизнесийн цар хүрээ нэмэгдэхийн хэрээр уг эрсдэлийн нөлөөлөл томорч, алдагдсан боломжийн зардал өсөж байна. Иймд Премиум Нэксус ХК нь ханган нийлүүлэлтийн найдвартай байдлыг хангах үүднээс нийт бараа бүтээгдэхүүний 99.99%-ыг өөрийн түгээлтийн төвөөр дамжуулан нэгдсэн бүтээгдэхүүн удирдлагаар уг эрсдэлийг бууруулан ажиллаж байна.

Өрсөлдөөний эрсдэл:



Жижиглэн худалдааны зах зээлд өрсөлдөөн нэмэгдэж ойролцоо байршил дах хүнсний дэлгүүр, конвиниенс дэлгүүрийн тоо нэмэгдсэнээр нэгж дэлгүүрийн болон дундаж борлуулалт буурах, хэрэглэгчдийн тоо хуваагдах эрсдэлтэй. Компани нь зах зээлд давамгайлах стратегийг хэрэгжүүлж, хүн амын хөдөлгөөний урсгал байршлуудад түргэн байршиж, өөр хоорондоо оновчтой зайтайгаар буюу 150-200 метрийн зайд конвиниенс дэлгүүрийг тэлснээр өрсөлдөөнд давуу байдлыг бий болгож, тус эрсдэлийг бууруулж ажилладаг.

Чадварлаг хүний нөөцийн хомсдол үүсэх эрсдэл



Жижиглэн худалдааны салбарт өрсөлдөгч нэмэгдсэн нь чадварлаг ажиллах хүчний хомсдол үүсэх эрсдэл бий болгож байна. Компанийн брэндингийг сайжруулах, бидний үнэт зүйлст нийцэх хүмүүсээр ажил горилогчийн сангаа бүрдүүлж, уг санг үргэлж нэмэгдүүлж, бизнесийн шаардлага хэрэгцээнд нийцсэн ажиллах хүч бэлтгэх хөтөлбөр боловсруулан уг эрсдэлийг бууруулж байна.